

GOBI
MONGOLIAN CASHMERE

ЖИЛИЙН
ТАЙЛАН 2020

ГОВЬ
ХУВЬЦААТ
КОМПАНИ



АГУУЛГА

1. МАНАЙ КОМПАНИ

Компанийн ерөнхий танилцуулга

Бизнес загвар

Түүхэн замнал

ТУЗ-ийн даргын мэндчилгээ

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

2. 2020 ОНД БИД

Бидний амжилтууд

Шинэ технологи, цахим шилжилт

Статистик мэдээ

2020 оны санхүүгийн үр дүн

Хөрөнгө оруулалт

Төсөвт төвлөрүүлсэн татвар хураамж

3. БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ноолуурын салбар

Дотоод зах зээл

Гадаад зах зээл

Онлайн худалдаа

Брэндүүд

Коллекциуд

Бидний харилцагчид

4. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Засаглалын бүтэц, үйл ажиллагаа

Засаглалын өөрийн үнэлгээний үр дүн

Хувьцаа эзэмшигчид

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Төлөөлөн удирдах зөвлөл

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны ажлын тайлан

ТУЗ-ийн дэргэдэх хороодын тайлан

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны хурлын мэдээлэл

Дотоод аудитын хэлтэс

Дотоод хяналтын тогтолцоо

Эрсдэлийн удирдлага

Компанийн бүтэц

Компанийн эрх бүхий албан тушаалтнууд

Хөрөнгийн зах зээл ба компанийн хувьцаа

Ногдол ашиг

5. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Тогтвортой хөгжил 2020 онд

Нийгмийн хариуцлага

Чанарын удирдлага

6. ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Говь ХК болон түүний охин компаниуд, нэгтгэсэн санхүүгийн тайлан (Аудитлагдаагүй)



МАНАЙ КОМПАНИ



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

КОМПАНИЙН ОНООСОН НЭР:	ГОВЬ хувьцаат компани
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:	Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
КОМПАНИЙН АЛБАН ЁСНЫ ХАЯГ:	Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Шуудангийн хаяг: Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг 36/434, Говь ХК Утас: (976)-70139977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobi.mn Веб сайт: www.gobi.mn Фэйсбүүк: GobiCashmere Онлайн дэлгүүр: www.gobicashmere.com
КОМПАНИЙН УДИРДЛАГА:	ТУЗ-ийн дарга: Дамбын ГЭРЭЛМАА Гүйцэтгэх захирал: Цагаачийн БААТАРСАЙХАН
ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ОГНОО:	1981 оны 9 сарын 5-ны өдөр
АЖИЛЧДЫН ТОО:	1,939
ҮЙЛДВЭРИЙН ХҮЧИН ЧАДАЛ:	1,150 тонн түүхий ноолуур боловсруулах 1,050 тонн ээрмэл утас, 30 тонн нарийн ээрмэл утас ээрэх 1,500,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 1,100,000 метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 162,000 ширхэг ноолууран пальто болон пиджак үйлдвэрлэх
ДЭЛГҮҮРИЙН ТОО:	Дотоод Улаанбаатар хот - 2 Дархан хот - 1 Гадаад Охин компани - 3 Салбар дэлгүүр - 1 Франчайз дэлгүүр - 24 Онлайн дэлгүүр - 13

БИЗНЕС ЗАГВАР БИДНИЙ ҮНЭ ЦЭНЭ

ХҮНИЙ НӨӨЦ

Бидний гол нөөц болох ажилтнуудын ур чадвар, мэдлэг туршлага нь хүний нөөцийн хөгжлөөр нэмүү өртөг үүсгэх гол боломж

ОЮУНЫ НӨӨЦ

Бидний ирээдүйн орлогын баталгаа, өрсөлдөх хүч болсон оюуны өмч, брэнд болон нэр хүнд

БАЙГАЛИЙН НӨӨЦ

Бидний ирээдүйн сайн сайхны үр үндэс болох байгалийн нөөц баялаг (түүхий ноолуур, ус, агаар, хөрс, бүтээгдэхүүн зэргийн эрүүл байдал)

САНХҮҮГИЙН НӨӨЦ

Дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага болон үйл ажиллагаанаас эх үүсвэртэй шаардлагатай санхүүжилт (зээл, баталгаа...)

ҮЙЛДВЭРИЙН НӨӨЦ

Говь ХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ хүргүүлэхэд шаардлагатай үйлдвэрлэлийн зориулалт бүхий биет материал болон хөрөнгө

НИЙГЭМ, ХАРИЛЦААНЫ НӨӨЦ


Говь ХК-ийн бусад бүх оролцогч талуудтай үүсэх харилцаа нь компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын баталгаа болно

БИДНИЙ ЗОРИЛТ

Говь ХК нь хүний хөгжил, технологиор тэргүүлэн, хэрэглэгч харилцагчдын сэтгэл ханамжийг хамгийн өндөрт хүргэж, хөрөнгө оруулагч, ажилтнуудын үнэ цэнэтэй байгууллага байна

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

Шударга, ил тод,
нээлттэй



Хууль, дүрмийг чандлан
сахиулна

Хүний эрхийг
дээдэлнэ

Бүтээлч сэтгэлгээг
хөгжүүлнэ

Байгаль орчинд ээлтэй
үйл ажиллагаа явуулна

ТҮҮХЭН ЗАМНАЛ

1976

UNIDO-ийн төслийн хүрээнд ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах туршилтын үйлдвэр ашиглалтад оров

1981

Ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэрийн машин тоног төхөөрөмжийн угсралт, тохируулгын ажлыг гүйцэтгэн, технологийн шугамыг ашиглалтад хүлээн авч, Монгол-Японы хамтын ажиллагааны хүрээнд дэх анхны байгууламж Говь үйлдвэр үүд хаалгаа нээлээ.

1991

Олон улсын ISO-9000 стандартыг үе шаттайгаар нэвтрүүлж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 98 хувийг экспортлон Олон улсын чанарын цом,гэрчилгээг авсан Монгол улсын анхны үйлдвэр боллоо

1997

Монголд анх удаа ноос ноолууран хөнжил, ноолууран давуу, драп, нарийн номерын ээрмэл утас үйлдвэрлэх "Говь-2" үйлдвэрийг ашиглалтад хүлээн авав.

2000

Утас будах технологи нэвтрүүлэв.Орчин үеийн компьютерын системд холбогдсон STOLL-330 сүлжих машиныг суурилуулав.

2008

Үйлдвэрийн дэргэдэх Төв дэлгүүрийн барилгын дизайныг Японы алдарт архитектурч Сако Кейчиро хийж, шинэ дэлгүүр 6 сард нээлтээ хийлээ.

2010

Говь үйлдвэр байгуулагдсаны 30 жилийн түүхт ойн хүрээнд Италийн алдарт загвар зохион бүтээгч Саверио Палателлатай хамтран ажиллах гэрээг байгууллаа.Монголын ноолуурын салбарт анх удаагаа Принт технологийг нэвтрүүлэв.

1977

Япон улсын Засгийн газраас БНМАУ-ын Засгийн газарт 5.0 тэрбум иенийн буцалтгүй тусламж олгож, Улаанбаатар хотноо ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэр байгуулах тухай Монгол-Японы Засгийн газрын хэлэлцээр байгуулав.

1987

Компьютерын автомат удирдлага бүхий Япон улсын SET-092сүлжих машиныг үйлдвэрт суурилуулав

1993

Монгол Улсын Засгийн газрын Өмч Хувьчлалын Комиссын тогтоолоор Говь УУГ-ыг Говь ХК болгон зохион байгуулж, МХБ-д бүртгүүлэн, нийт дүрмийн сангийн 25.1% буюу 1,919,061 ширхэг хувьцаа нь хөрөнгийн биржээр арилжаалагдсан.

1998

Гадаад зах зээлээ өргөжүүлэн Япон улсад "Алтай", Бельги улсад "Gobi Europe", АНУ-д "Gobi-USA" зэрэг охин компаниуд байгуулж, дэлхийн 30 гаруй оронтой түншийн харилцаа тогтоов.

2007

Говь компанийн төрийн өмчлөлд байсан 73.45%-н хувьцааг "ЭФ СИ АЙ" ХХК Олон улсын нээлттэй дуудлага худалдаагаар худалдан авснаар Говь ХК хувийн эзэмшилд бүрэн шилжлээ.

2009

Японы Токио хотод салбар дэлгүүрээ нээлээ. Италийн "VVA Consulting Company"-тай хамтран ажиллах гэрээг байгууллаа.Говь Үйлдвэрт техник, технологийн шинэчлэлтүүдийг үе шаттайгаар хийсэн.

2011

Үйлдвэрлэлийн хүчин чадлаа 2 дахин нэмэгдүүлэв. Италийн алдарт хувцас загвар зохион бүтээгч Саверио Палателлатай хамтарсан анхны коллекци "Gobi by Saverio Palatella" коллекци худалдаанд гарлаа. "Говь" ХК-ийн 30 жилийн ойг тэмдэглэв.

2013

Үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж Whole Garment буюу оёдолгүй сүлжмэл бүтээгдэхүүний шинэ технологийг нэвтрүүлэв.

2015

Японы алдарт Киосера компанийн үндэслэсэн АМЭБ менежментийг бие даан нэвтрүүлж эхэллээ.

2017

Оёмлын шинэ үйлдвэрийг ашиглалтад оруулан 100,000 ширхэг ноолууран пальто, пиджак үйлдвэрлэх хүчин чадалтай боллоо. Интернет худалдааг эхлүүлж, өөрийн онлайн худалдааны www.gobicashmere.com гэсэн сайттай болсон.

2019

Говь ХК нь Гоёо ХХК-г нэгтгэн авч, салбарын хамгийн том нэгдлийг амжилттай гүйцэтгэлээ.

2012

Улаанбаатар хотын төвд Төв шуудангийн урд шинэ салбар дэлгүүрээ нээж хэрэглэгчдэдээ улам ойртлоо. Gobi by Saverio Palatella 2012 оны Намар, Өвлийн шинэ коллекци гаргав.

2014

Монгол ямааны ноолуурын үндсэн 4 өнгө болох цагаан, цайвар шаргал, бор, хөх саарал өнгийн ноолуурыг цайруулж будахгүйгээр байгалийн өнгөөр нь бэлэн бүтээгдэхүүн болгон гаргасан "Gobi-Mongolian Organic Cashmere" брэндийг худалдаанд гаргалаа.

2016

100% ноолууран пальтоны үйлдвэрлэлээрээ дэлхийд №1 болно гэдгээ олон нийтэд зарлалаа. ХБНГУ-д анхны албан ёсны салбар дэлгүүрээ нээлээ.

2018

Ээрмэлийн үйлдвэрт Италийн Bigagli мөлхөө ээрэх машиныг шинээр нэвтрүүлж, сүлжмэлийн бүх утсыг мөлхөө ээрэхэд шилжүүлж, утасны чанарыг сайжрууллаа. Мөн ноолууран пиджакийн масс үйлдвэрлэлийг эхлүүлж, дэлхийд ноолууран пиджак үйлдвэрлэлээрээ тэргүүллээ.

2020

Говь ХК нь Төрийн дээд шагнал Сүхбаатарын Одонгоор шагнуулав. Онлайн сувгуудыг шинээр Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Норвегийн Вант Улс, Шведийн Вант Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын зах зээлд тус тус нээлээ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Д. ГЭРЭЛМАА

Хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Бид 2020 оны үйл ажиллагааны үр дүн, амжилт ололт болон цаашид сайжруулан хөгжүүлэх ажлуудаа тайлагнах хариуцлагатай цаг ирлээ.

"Говь ХК" анх 1981 онд байгуулагдаж, олон хүний хичээл зүтгэл, хүч хөдөлмөр шингэн өдийг хүртэл амжилттай үйл ажиллагаа явуулж байна. Манай компани Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индексийн багцад багтдаг бөгөөд хөрөнгийн зах зээлд идэвхтэй байр суурьтай билээ. Бид 2020 онд "Шилдэг хувьцаат компани"-аар шалгарч, үндэсний том үйлдвэрлэгч, салбартаа тэргүүлэгчийнхээ манлайллыг улам бүр бэхжүүлсний зэрэгцээ томоохон түүхэн үйл явдал тохиосон нь "Говь ХК" төрийн дээд шагнал Сүхбаатарын Одонгоор шагнуулсныг дурдах нь зүйн хэрэг юм. Шагналын эзэд болох үе үеийн удирдлага, одоогийн баг хамт олон, нийт ажиллагсдадаа халуун баярыг ахин хүргэе!

2020 он бидэнд амжилт ололтыг мөн сорилтуудыг ч авчирсан жил байлаа. Дэлхий дахиныг хамраад буй КОВИД-19 цар тахлын байдал бидний үйл ажиллагаанд тодорхой нөлөөлөл үзүүлсэн ч бид сайн засаглалын зарчмууд, чадварлаг гүйцэтгэх удирдлагын баг, ажиллагсдын хичээл зүтгэл болоод стратегийн чиг хандлагуудыг баримтлан үүсэж буй нөхцөл байдалд түргэн хариу арга хэмжээ авч ажиллалаа. Хэдий эдийн засгийн нөхцөл байдал болоод манай улсад ирэх жуулчдын урсгал зогссон нь дотоодын борлуулалтад нөлөөлсөн ч бид олон улсын зах зээлд шинэ онлайн сувгуудыг амжилттай нээж, онлайн борлуулалтаа 6 дахин өсгөж чадлаа.

Бид цаашид цар тахлын энэхүү нөхцөл байдалд эрсдэлүүдээ тооцон, эрүүл мэндийн аюулгүй байдлыг чанд сахин ажиллаж, дотоод болон олон улсын онлайн сувгуудаа улам хөгжүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.

2020 онд амаргүй цаг хугацаанд зорилгодоо хүрэхийн тулд бүтээлч, шантралгүй ажилласан компанийн удирдлагууд, ТУЗ-ийн гишүүд болон нийт ажиллагсдадаа талархал дэвшүүлье.

Та бүхэнд ажлын өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц. БААТАРСАЙХАН

Хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, бизнесийн түнш, хамтран ажиллагсад та бүхэндээ чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

“Дэлхийд танигдсан Монгол брэнд” уриатай “Говь” ХК үүсгэн байгуулагдаад эдүгээ 40 дэх жилдээ амжилттай үйл ажиллагаагаа явуулж байна. Түүхэн энэ жилүүдэд байгууллагын маань үе үеийн удирдлага, ажилчид, хамт олны хүчин зүтгэл, хөдөлмөрийн үр дүнг төрөөс өндрөөр үнэлж, “Говь” ХК-ийг маань төрийн дээд шагнал Сүхбаатарын Одонгоор шагнасныг цохон тэмдэглэхэд таатай байна. Бид улам өргөжин тэлэх зорилгоор борлуулалтын суваг, боломжийг эрэлхийлж анх 2019 оны 2 дугаар хагас жилд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Америкийн Нэгдсэн Улс,

Бүгд Найрамдах Хятад Ард Улс зэрэг онлайн сувгуудыг нээж эхэлсэн бол 2020 онд Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Норвегийн Вант Улс, Шведийн Вант Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын зах зээлд нэвтрэхийн зэрэгцээ дэлхийн өнцөг бүрд хүрч, Говь брэндийг түгээх үйл ажиллагаагаа амжилттай явуулсаар байна. Онлайн борлуулалтын сувгийг тэлж, хөгжүүлэх стратеги, маркетингийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд 2020 онд зөвхөн эдгээр сувгуудын борлуулалт 30 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 6 дахин өссөн үзүүлэлт байлаа. Бид цаашид, хурдтай хөгжиж буй технологийн хөгжлийг даган, цахим худалдааны сувгуудыг дотоод болон гадаад зах зээлд улам хөгжүүлэн, өргөжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

2019 оны сүүлээс дэлхий дахиныг донсолгож буй коронавируст цар тахал манай оронд ч хүчтэй нөлөөлж, зөвхөн “Говь” ХК-аар зогсохгүй хувь болон төрийн хэвшлийн олон байгууллагын хурдан хариу арга хэмжээ авах бэлтгэл, чадамжийг шалгасаар 2020 оныг үдлээ. Хэцүү бэрх энэ үед хувьцаа эзэмшигчид та бүхний итгэл, чадварлаг баг хамт олныхоо хүчээр бид нөхцөл байдалд тохирсон оновчтой арга хэмжээг, түргэн шуурхай авч хэрэгжүүлсний дүнд оролцогч талуудын эрх ашгийг боломжит хамгийн өндөр түвшинд хүргэн ажиллаж чадлаа. Бид олон улсад өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж, дэлхийн хэрэглэгчид илүү танигдсан компани болох туйлын зорилготойгоор 2019 онд “Гоёо” ХХК-ийг өөртөө нэгтгэж байсан бол энэхүү зорилгодоо хүрэх дараагийн алхмуудыг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлсээр байна.

Миний бие тус компанийн гүйцэтгэх захирлын хувиар “Говь” ХК-ийг зах зээлд тэргүүлэгчийн байр сууриа хадгалж, олон улсад үйл ажиллагаагаа улам тэлж, эх орныхоо эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулах, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, ХАРИЛЦАГЧ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, АЖИЛТНУУДЫНХАА САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ хөнгөн үйлдвэрлэлийн салбарын жишиг компани хэвээр байлгахыг эрхэм зорилго болгож, байгальд ээлтэй үйл ажиллагааг дэмжиж ажиллах болно.

Биднийг үргэлж дэмжиж байдаг та бүхэндээ сайн сайхан, эрүүл энхийг хүсэж, цаашдын ажил үйлст тань өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе!



2020 ОНД БИД

БИДНИЙ АМЖИЛТУУД

ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА

2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ТОП-100” ААН-ийг шалгаруулах ёслол анх удаа цахимаар зохион байгуулагдаж, Говь ХК 19 дүгээр байранд шалгарлаа.




МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДЭЭД ШАГНАЛ “СҮХБААТАРЫН ОДОН”

Монголын Үндэсний Худалдаа, Аж үйлдвэрийн танхимын 60 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баялаг бүтээгчдэд төрийн дээд одон, медаль гардуулах ёслол 2020 оны 9 сарын 26-ны өдөр зохион байгуулагдаж, “мал аж ахуйн гаралтай түүхий эдэд нэмүү өртөг шингэсэн эцсийн боловсруулалт хийж, олон улсын стандарт шаардлагыг хангасан өндөр чанар, загвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Монгол Улсын экспортод чиглэсэн улс болох үндэсний ашиг сонирхлыг манлайлан ажиллаж, улсынхаа эдийн засаг, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан үе үеийн ажилтан албан хаагчдын гавьяа зүтгэлийг өндрөөр үнэлж” “Говь” ХК-ийг Төрийн дээд шагнал Сүхбаатарын одонгоор шагналаа.



ШИНЭ ТЕХНОЛОГИ, ЦАХИМ ШИЛЖИЛТ

ГОВЬ ХК – ИЙН ЦААШДЫН ЦАХИМ ШИЛЖИЛТ




“Говь” ХК - ийн цаашид хэрэгжүүлэх “Цахим Шилжилт” нь хэрэглэгчтэй харьцах талдаа найдвартай, ашиглахад хялбар, хурдан шуурхай ажилладаг байхаар зохион байгуулагдах бөгөөд үндсэн системүүд дээр ажиллах ажилчдын ашиглах системүүдийн зохион байгуулалт нь мөн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, ажилтны ажиллах чадамжийг нэмэгдүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэхэд зорьсон шилжилт байх юм.

СТАТИСТИК МЭДЭЭ

НИЙТ АЖИЛТНУУДЫН ТОО 1,939



ЗАХИРГАА-191



ҮЙЛДВЭР-1,458




БОРЛУУЛАЛТ-267




ОХИН КОМПАНИ-23

АЖИЛТНУУДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА




29%




71%

БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



ДЭЭД-811



БҮРЭН ДУНД-565




ТУСГАЙ ДУНД-563

2020 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮН


ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2019 он	2020 он (Аудитлагдаагүй)		
		Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Өмнөх оноос өөрчлөлт	
				дүн	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.төг	209,748	117,098	(92,650)	(44)%
Үүнээс: Дотоод борлуулалт	сая.төг	134,758	49,471	(85,287)	(63)%
Гадаад борлуулалт	сая.төг	65,330	36,021	(29,308)	(45)%
Онлайн борлуулалт	сая.төг	9,661	31,606	21,945	227%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	сая.төг	141,952	71,529	(70,423)	(50)%
НИЙТ АШИГ	сая.төг	67,796	45,569	(22,227)	(33)%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	59,848	86,043	26,195	44%
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	3,861	7,035	3,175	82%
Татварын өмнөх ашиг	сая.төг	4,087	(47,510)	(51,597)	(1262)%
ЦЭВЭР АШИГ	сая.төг	2,456	(46,182)	(48,638)	(1980)%
Нийт үйл ажиллагааны зардал	сая.төг	201,800	157,573	(44,227)	(22)%
Орлогын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.96	1.35	0.38	40%
ҮЙЛДВЭРЛЭЛ					
Сүлжмэл	зуун.шир	9,720	9,540	(180)	(2)%
Нэхмэл	зуун.шир	4,184	2,200	(1,948)	(47)%
Оёмол	зуун.шир	795	493	(302)	(38)%
Үүнээс: Пальто	зуун.шир	484	287	(197)	(41)%
Пиджак	зуун.шир	93	96	3	3%
Ээрмэл	тонн	275	226	(49)	(18)%
АЖИЛТНУУДЫН ТОО	хүн	2,612	1,939	(673)	(26)%
Нэг ажилтанд ногдох орлого	мян.төг	80,302	60,391	(19,911)	(25)%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.төг	60,517	916	(59,601)	(98)%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2007 оноос хойш нийт хөрөнгө оруулалт 147.7 тэрбум төгрөг




2007 оны хувьчлалаас хойш өссөн дүнгээрээ нийт 147.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2019 онд 60 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 23 тэрбум нь "Говь" ХК-ийн барилга байгууламж, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгө оруулалтад зарцуулагдсан бол үлдсэн 37 тэрбум төгрөг нь "Гоёо" ХХК нэгдсэний дүнд үүссэн өсөлт байв. 2020 онд 916 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 243 сая төгрөг буюу 26%-ийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 273 сая төгрөг буюу 30%-ийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 261 сая төгрөг буюу 29%-ийг бусад хөрөнгө оруулалтад зориулсан байна. Харин биет бус хөрөнгүүд болох барааны тэмдэгт, программ хангамжид 138 сая төгрөг буюу 15%-ийн хөрөнгө оруулалт хийсэн байна.



ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ

"Говь" ХК нь 2007 оноос хойш зөвхөн Монголын татварын албанд нийт 153.2 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. Үүнийг нэр төрөл болон он цагалбараар дэлгэрүүлэн доор харуулав.





БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА


НООЛУУРЫН САЛБАР

Монгол улсад 2020 онд 27.7 сая тоо толгой ямаан сүрэг тоологдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 сая буюу 5.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Манай улс 2020 онд 10,170 орчим тонн ноолуур бэлтгэсэн нь өмнөх оноос 7.1 хувийн бууралттай үзүүлэлт бөгөөд дэлхийн түүхий ноолуурын 48 хувийг хангаж байна. Ноолуурын дундаж үнэ 67,250 төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 39.8 хувиар буурсан үзүүлэлт болж байна.




СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН МОНГОЛ УЛСЫН НООЛУУРЫН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ:

Монгол улсын ямааны тоо толгой



Монгол улсын түүхий ноолуурын бэлтгэл



Түүхий эдийн дундаж үнэ



Ноолуурын зах зээл




ДОТООД ЗАХ ЗЭЭЛ

↓ 63%

2020 онд дотоод борлуулалт 49.5 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 63% бууралттай байсан. Дэлхий даяар үүсээд буй Ковид-19 цар тахлын нөхцөл байдал борлуулалтад тодорхой нөлөөлөл үзүүлсэн. Говь ХК нь Монгол Улсын ноолууран бэлэн бүтээгдэхүүний зах зээлийн 83%-ийг эзэлж байна.

ДОТООД ЗАХ ЗЭЭЛД




ХУДАЛДАН АВАГЧИД

Худалдан авагчдын тоо 2019 онтой харьцуулахад 61% буурсан. Ковид-19 цар тахлын нөхцөл байдал худалдан авалт болоод гадаад жуулчдын урсгалд шууд нөлөөлөл үзүүлсэн.

2019 онд нийт 367,418
2020 онд нийт 142,948

/мян. хүн/



БОРЛУУЛАЛТЫН ШИНЭ СУВГУУД



2020 оны 11 дүгээр сараас эхлэн Shopyy.mn болон Tok Tok цахим худалдааны платформуудаар бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн. Манай бүтээгдэхүүнүүд болох цамц малгай сет, сүлжмэл өмд, сүлжмэл малгай, нэхмэл ороолт, сүлжмэл бээлий, сүлжмэл оймс борлуулалтаараа bestseller байв.

Shopyy.mn BESTSELLER



ЦАМЦ МАЛГАЙ
СЕТ



СҮЛЖМЭЛ ӨМД



СҮЛЖМЭЛ
МАЛГАЙ

Tok Tok BESTSELLER




НЭХМЭЛ ОРООЛТ



СҮЛЖМЭЛ
БЭЭЛИЙ



СҮЛЖМЭЛ ОЙМС



2020 ОНЫ БРЭНДИЙН ҮНЭ ЦЭНЭ ӨСГӨСӨН, ӨНДӨР ХАНДАЛТТАЙ КОНТЕНТ



18,095



2,947

PEOPLE REACHED

730,721

ENGAGEMENTS

206,694

“МАЛЧНЫ ХОТНООС ДЭЛХИЙД”-GOBI FW 20/21 КОЛЛЕКЦИ

“Малчны хотноос дэлхийд”-намар/өвлийн коллекцийн зураг пост хийснээс 10 сараас хойш Gobi Cashmere хуудасны хандалт өсөж 303,888 дагагчтай болсон.

2020 ОНД ТАНИГДСАН БАЙДЛАА НЭМСЭН ХОЁР КОНТЕНТ



7,204



1,060

PEOPLE REACHED

563,199

ENGAGEMENTS

107,348



GOBI FW 2020 ЗАГВАРЫН ШОУ

2020 оны 10-р сарын 23-нд намар/өвлийн шинэхэн коллекци худалдаанд гаргасантай холбогдуулан социал медиад олон дагагчтай, тансаг зэрэглэлийн хувцас таашаадаг, олны танил бүсгүйчүүдийг нэг дор цуглуулан PRESENTATION загварын шоу зохион байгууллаа. Загварын шоугаар Говь брэнд малчны хотноос түүхий эдийг боловсруулан бэлэн бүтээгдэхүүн болгон дэлхийд зах зээлд гаргаж, хэрхэн амжилт олсон тухай, шинэ коллекцийн ур хийц, ноолууран хувцасны үнэ цэнийг танилцуулж амжилттай зохион байгууллаа.

2021 ОНД

- Зах зээлд байр сууриа хадгалах. Хувь захиалга, хатгамал зэрэг нэмэлт үйлчилгээг нийтэд илүү таниулах.
- Дотоод зах зээлд өөрийн веб хуудсаар дамжуулан онлайн худалдааг 2021 оны 8 сараас эхлүүлнэ. Онлайн худалдан авалтыг залуучууд түлхүү сонгон хэрэглэдэг тул дараагийн үеийн үнэнч хэрэглэгчдийг бий болгох ач холбогдолтой.
- Бэлгийн картыг нийтэд таниулах, хоногшуулах, борлуулалтыг өсгөх.
- Мерчиндайзингийг чухалчлах. Нэг дороос олон төрлийн бүтээгдэхүүн сонгон худалдан авах боломжийг бүрдүүлэх.



ГАДААД ЗАХ ЗЭЭЛ

↓45%

36.0

тэрбум төгрөг

2020 онд гадаад борлуулалт 36 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 45% бууралттай байсан. Дэлхий даяар үүсээд буй Ковид-19 цар тахлын нөхцөл байдал борлуулалтад тодорхой нөлөөлөл үзүүлээ.

2020 оны сүүлийн байдлаар 8 улсын 19 хотод 24 франчайз дэлгүүр, 1 салбар дэлгүүр, 3 охин компанитай үйл ажиллагаа явуулж байна. БНСУ-н зах зээлд одоогийн байдлаар Hyundai, CJ ENM homeshopping дамжуулан борлуулалт хийдэг бөгөөд 2021 онд цаашид LOTTE homeshopping борлуулалтын суваг нэмэхээр төлөвлөн ажиллаж байна.




ФРАЙНЧАЙЗ ДЭЛГҮҮРҮҮД:

- Алматы
- Киев
- Прага (2)
- Хөх хот
- Анкара
- Кызыль
- Сөүл (3)
- Хабаровск
- Бээжин
- Манжуур
- Токио
- Хонконг (3)
- Истанбул
- Новосибирск
- Улан-Удэ
- Эрээн хот
- Иркутск
- Омск
- Хайлаар

ОНЛАЙН ХУДАЛДАА

Говь ХК нь дэлхийн олон улс оронд өөрийн салбар дэлгүүр болон франчайз дэлгүүрээр дамжуулан бараа бүтээгдэхүүнээ борлуулдаг. Мөн үүний хажуугаар онлайн сувгаар дамжуулан бараа бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд борлуулж ирсэн бөгөөд 2019 оны 7 сараас эхлэн онлайн худалдаанд илүү анхаарлаа хандуулан ажиллаж эхэлсэн.

2020 онд онлайн борлуулалтын сувгуудаа улам тэлж Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Норвегийн Вант Улс, Шведийн Вант Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын зах зээлд тус тус амжилттай нэвтрээд байна. Бид цаашид "Online" борлуулалтын сувгаа илүү хөгжүүлэн тэлэх бодлогыг баримтлан ажиллана.



ЯАГААД ДЭЛХИЙД ГЭЖ?

ГОВЬ ЯАГААД ОРШИН ТОГТНОДОГ ВЭ?



ХЭРЭГЛЭГЧ

Дэлхийд гайхагдах Монгол ноолуурын тав тух, тансаг мэдрэмжийг мэдрэх боломжийг хүн бүрд олгох.



НИЙГЭМ

Үндэсний үйлдвэрлэгч компанийн хувьд эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх

Ноолуурын салбарын урт хугацааны хөгжлийг түүчээлэх

Хүн бүр 100% Монгол ноолуурын тав тух, тансаг мэдрэмжийг мэдрэч чаддаг бол дэлхий илүү сайхан болно гэдэгт бид итгэдэг.



ГОВЬ ХК – ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД ӨРСӨЛДӨХ СТРАТЕГИ

<p>БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ (B2B)</p> <p>Брэндүүдэд болон борлуулагчдад захиалгаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж өгөх</p> <p>ДАВУУ ТАЛ: Үйл ажиллагааны цар хүрээ зохион байгуулахад хялбар. Брэндинг, маркетингийн ажиллагаа шаардлагагүй.</p> <p>СУЛ ТАЛ: Нэмүү өртөг бага шингэх тул ашгийн хувь бага. Урт хугацаанд оршин тогтнох баталгаагүй.</p>	<p>ХЭРЭГЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ (B2C)</p> <p>Говь брэндийн нэрийг ашиглан борлуулагч нарт үйлдвэрлэж өгөх болон өөрсдийн дэлгүүрт борлуулах борлуулалт.</p> <p>ДАВУУ ТАЛ: Ашгийн түвшин B2B-ээс өндөр. Борлуулалт, маркетингийн үйл ажиллагааг зохион байгуулахад D2C-ээс хялбар</p> <p>СУЛ ТАЛ: Дэлгүүрийн түрээсийн зардал өндөр.</p>	<p>ОНЛАЙН ХУДАЛДАА (D2C)</p> <p>Говь брэндийн нэрээр ямар нэгэн дундын дамжлага, дэлгүүрийн шаардлагагүйгээр хэрэглэгчид хүргэгдэнэ</p> <p>ДАВУУ ТАЛ: Ахиуц ашиг өндөр. Брэндинг болон дата бааз нэмэгдэх тул урт хугацааны өсөлтийг үзүүлэх боломж хамгийн өндөр. Борлуулалт маркетингийн үйл ажиллагааг уялдуулах чадамжийг бий болгох.</p> <p>СУЛ ТАЛ: Эхлэлийн үед нийтэд танигдах зардал өндөр.</p>
--	---	---

D2C ОНЛАЙН ХУДАЛДАА

1. Хэрэглэгч ГОВЬ брэндийн сурталчилгаагаар дамжин, эсвэл шууд дэлгүүрт нэвтрэх.

Хайлтын систем:



Сошиал медиа:



Бусад:




2. Хэрэглэгч онлайн худалдааны 13 дэлгүүрээс өөрт ойр болон өөрийн хүссэн хэлээр сонгон үйлчлүүлж худалдан авалт хийнэ.



www.gobicashmere.com

3. Герман, Америк, Хятад дахь Говь ХК-ийн агуулахуудаас хэрэглэгчийн бүтээгдэхүүнийг хүргэлтийн компанид хүлээлгэж өгнө.



4. Хүргэлтийн компаниар дамжуулан хэрэглэгчид хүлээлгэн өгнө.





ОНЛАЙН БОРЛУУЛАЛТЫН СУВГИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2020/01

3 ДЭЛГҮҮР
-Gobi North America
-Gobi International
-Gobi Germany

2020/03

"MARTIN PARKER"
-Хувцас дизайнер Мартин Паркер хамтарсан
хавар зуны коллекцийн нээлт
-Анхны онлайн коллекцийн нээлт хийв.

2020/06

"UK, RU"
Англи, Орос онлайн дэлгүүрүүдээ нээж үйл
ажиллагаа явуулж эхлүүлсэн.

2020/09

"CN, SE, NO"
Хятад дахь "Tmall, JD" дэлгүүрүүд болон
Швед, Норвеги онлайн дэлгүүрүүдээ нээв.

2020/11

Английн алдарт "THE SUNDAY TIMES"
Английн алдарт "The Sunday Times" сэтгүүл дээр
анх удаа хэвлэгдэн гарав.

2020/02

"GOOGLE"
"Google" компанийн ази дахь төв оффистой
бизнесийн түншлэл эхлүүлсэн.

2020/05

"OGILVY"
Дэлхийн #1 маркетингийн компани "Ogilvy"-той
судалгаа брэндингийн хамтрал эхлүүлсэн.

2020/07

"FR, PL"
Франц, Польш онлайн дэлгүүрүүдээ нээж үйл
ажиллагаагаа тэлэв.


2020/10

"CN-WECHAT"
- "Wechat" албан ёсны дэлгүүр (mini-app) нээгдэв.

2020/12

13 ДЭЛГҮҮР
1. Gobi North America
2. Gobi International
3. Gobi Germany
4. Gobi UK
5. Gobi Russia
6. Gobi France
7. Gobi Poland
8. Gobi Sweden
9. Gobi Norway
10. Gobi China
- Tmall
- JD
- Wechat
- Taobao

ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ 2020/2019



(тайлбар: "x"-дахин)

IMPRESSION

Нийт дижитал маркетингийн сурталчилгаа маркетингийн хэрэглэгчдэд хүрсэн

SESSION

Онлайн дэлгүүрийн нийт зочлолтын тоо

CR%

Conversion rate
Нийт вэбрүү зочилсон зочлолтын хэдэн хувь нь худалдан авалт хийж буйг илэрхийлэх хувь

CPA

Cost per Acquisition
Нэг захиалга хийлгэхэд гаргаж буй маркетингийн зардал

ORDER

Худалдан авалт буюу хэрэглэгчдийн нийт захиалгын тоо ширхэг

SALES

Борлуулалтын үнийн дүн



GOBICASHMERE.COM

385 загвар худалдаалж байна.
Өдөр бүр дунджаар 1.3 сая орчим хүнд сурталчилгаа хүрсэн.
67% гар утас, 11% таблет, 22% компьютер ашигласан.
Өдөр бүр дунджаар 7,000 гаруй хүн дэлгүүрээр зочилсноос
Эмэгтэй 67%, Эрэгтэй 33%

GOBICASHMERE.COM/WEE

385 загвар худалдаалж байна.
Өдөр бүр дунджаар 1.1 сая орчим хүнд сурталчилгаа хүрсэн.
62% гар утас, 14% таблет, 24% компьютер ашигласан.
Өдөр бүр дунджаар 9,500 гаруй хүн дэлгүүрээр зочилсноос
Эмэгтэй 67%, Эрэгтэй 33%

GOBICASHMERE.COM/DE

385 загвар худалдаалж байна.
Өдөр бүр дунджаар 1.6 сая орчим хүнд сурталчилгаа хүрсэн.
72% гар утас, 8% таблет, 20% компьютер ашигласан.
Өдөр бүр дунджаар 4,500 гаруй хүн дэлгүүрээр зочилсноос
Эмэгтэй 66%, Эрэгтэй 34%



GOBICASHMERE.COM/US

334 загвар худалдаалж байна.
Өдөр бүр дунджаар 1.2 сая хүнд орчим сурталчилгаа хүрсэн.
61% гар утас, 4% таблет, 33% компьютер ашигласан.
Өдөр бүр дунджаар 4,800 гаруй хүн дэлгүүрээр зочилсноос
Эмэгтэй 61%, Эрэгтэй 31%



GOBI.TMALL.COM

255 загвар худалдаалж байна.
Өдөр бүр дунджаар 530 мянган орчим хүнд сурталчилгаа хүрсэн.
99% утасгүй сүлжээгээр ханддаг.
Өдөр бүр дунджаар 3,500 гаруй хүн гаруй хүн дэлгүүрээр зочилсноос
Эмэгтэй 88%, Эрэгтэй 12%

GOBICASHMERE.COM

БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

2020 онд нийт 20.8 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж, борлуулалт өнгөрсөн оноос 8.5 дахин өсөв.

2020 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ САРААР




Борлуулалтын орлого /сая төгрөг/

WEBSITE, сувар	Улс	Борлуулалт
www.Gobicashmere.com/de	Герман	12,157
www.Gobicashmere.com	Европын бусад улс	3,681
www.Gobicashmere.com/uk	Их Британи	2,381
www.Gobicashmere.com/ru	Орос	869.5
www.Gobicashmere.com/fr	Франц	855.5
www.Gobicashmere.com/pl	Польш	578.9
www.Gobicashmere.com/se	Швед	198.5
www.Gobicashmere.com/no	Норвеги	67
НИЙТ		20,788

Герман улс дахь салбар дэлгүүрийн борлуулалт 2 тэрбум төгрөг байв.

2020 оны 2-р хагасаас эхлэн Их Британи, Франц, ОХУ, Польш, болон Швед улсуудад Website-ууд нээгдсэн бөгөөд бүтээгдэхүүнээ худалдаалж эхэлсэн.

БОРЛУУЛАЛТ, ОНЛАЙН СУВГААР



Европын зах зээлд Говь брэндийг таниулж борлуулалт өсгөх зорилгоор дижитал болон хэвлэмэл хэлбэрээр тухайн улсын болон олон улсын нэр хүндтэй сонин сэтгүүлд гарах ажлууд хийгдэж эхэлсэн. Жишээ нь, Их Британи улсын зуун жилийн түүхтэй Sunday Times болон Telegraph хэвлэмэл болон дижитал сонин, ОХУ-ын нэр хүндтэй Гламур сэтгүүл, Францын Gala сэтгүүлүүдэд тус тус бүтээгдэхүүнээ онцолсон.

Ogilvy Дэлхийд алдартай Ogilvy-аас Онлайн худалдааг хурдасгаж өргөжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээг авч ажилласан.

GOBICASHMERE.COM-DACH RAUM

GERMANY | SWITZERLAND | AUSTRIA

www.gobicashmere.com/de




БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

2019 оны 12 дугаар сараас эхлэн онлайн худалдаа хийгдэж эхэлсэн бөгөөд 2020 онд 12.2 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллав.

2020 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ САРААР

Борлуулалтын орлого /сая төгрөг/



GOBICASHMERE.COM - WESTERN AND EASTERN EUROPE

UNITED KINGDOM | INTERNATIONAL | POLAND | FRANCE
RUSSIA | SWEDEN | NORWAY

www.gobichashmere.com/uk
www.gobichashmere.com


www.gobichashmere.com/pl
www.gobichashmere.com/fr

www.gobichashmere.com/ru
www.gobichashmere.com/se

www.gobichashmere.com/no


БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

WEE бүлэг 2020 оны 1 дүгээр сараас, Орос, Польш, Франц улсуудад, 2020 оны 7 сараас онлайн худалдаа хийгдэж эхэлсэн бөгөөд 2020 онд нийт 8.6 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж гүйцэтгэв.



2020 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ САРААР

Борлуулалтын орлого /сая төгрөг/



GOBICASHMERE.COM-NORTH AMERICA



БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

2019 оны 9 дүгээр сараас эхлэн онлайн худалдаа хийгдэж эхэлсэн бөгөөд 2020 онд борлуулалтаа 4.3 дахин өсгөв.



2020 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ САРААР

Борлуулалтын орлого /сая төгрөг/



2020 оноос эхлэн АНУ-с Австрали болон Шинэ Зеланд улсууд руу бүтээгдэхүүнээ борлуулдаг боллоо.

GOBI ONLINE-CHINA

TMALL | TAobao | JD | WECHAT

gobi.tmall.com

gobicashmere.world.taobao.com

mall.jd.com/index-10266660.html

Wechat: GobiCashmereOfficial


БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

2020 онд 3.1 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж, борлуулалт өнгөрсөн оноос 3 дахин өсөв.



2020 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ САРААР

Борлуулалтын орлого /сая төгрөг/



БРЭНДУУД



GOBI
MONGOLIAN CASHMERE

Дэлхийд танигдсан монгол брэнд
GOBI MONGOLIAN CASHMERE брэнд



GOBI ORGANIC
MONGOLIAN CASHMERE

Ноолуурын байгалийн үндсэн 4 өнгө болох цайвар, цайвар шаргал, хөх саарал, бор өнгүүдийг ашигласан, будаагүй, цайруулаагүй GOBI ORGANIC CASHMERE брэнд





Илүү загварлаг, илүү тансаг зэрэглэлийн YAMA брэнд

Монголоор "Ямаа" буюу тансаг, дулаан ноолуурыг бий болгодог таван хошуу малын нэгээр нэрлэсэн бол Японоор Yama гэх үг нь "Уулын оргил" гэсэн утгатай. Дэлхийн зах зээлд хэдийнээ танигдсан ГОВЬ брэнд тансаг зэрэглэлийн ноолууран бүтээгдэхүүний зах зээлд хүч үзэхийг билэгдэн ийнхүү нэрлэсэн.





Монгол ноолуураар дэлхийг гоёно.
Goyo Mongolian Cashmere брэнд





Хүүхдийн хөдөлгөөнд саадгүй, хөнгөн, зөөлөн, загварлаг KID GOYO хүүхдийн брэнд





БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

"HERDERS" буюу МАЛЧИД төсөл нь Монгол ноолуурын үндэс сурвалж болсон нүүдлийн мал аж ахуй, нутаг бэлчээрийг хадгалах, сэргээхийн төлөө, малчдын гар дээрээс бэлтгэсэн сайн чанартай түүхий эдээр бүтээсэн сул чөлөөтэй, хувиран хөрвөх хэлбэр бүхий эрхэмсэг хэрнээ энгийн оршихуйг илэрхийлсэн загваруудыг танилцуулж байна.



ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ТЕХНОЛОГИ



БАДАМЛЯНХУА БАРЛАСАН
ШААЛЬ



АРАБ АЛЧУУР



ХҮҮХДИЙН ЗАГВАР



ХҮННҮ ХОСЛОЛ



1/24 номерын 2 талт жин хөнгөрүүлсэн драп шинээр хийж масс үйлдвэрлэлд нэвтрүүлээд байна.



2/24 номерийн 1 талт Shaggy боловсруулалттай драп шинээр хийж масс үйлдвэрлэлд нэвтрүүлээд байна.



“ОНЦЛОГ БҮТЭЭГДЭХҮҮН” ШАГНАЛ

Шинээр үндэсний монгол хэв маягийг орчин үеийн загвартай уялдуулан “Хүннү хослол” бүтээсэн ба “Ноос, ноолуур арьс ширэн бүтээгдэхүүн-2020” үзэсгэлэн худалдаанд техник, технологийн өвөрмөц шийдэл, арга барилаар үйлдвэрлэгдсэн “ОНЦЛОГ БҮТЭЭГДЭХҮҮН”-ээр шалгарлаа.

КОЛЛЕКЦУУД



HERDERS BY GOYO



ЦАГААН САР КАПСУЛ
КОЛЛЕКЦИ



KID GOYO
КОЛЛЕКЦИ



МАРТ 8 КОЛЛЕКЦИ



ДОМОГТ ШУВУУНЫ
ХАТГАМАЛТАЙ ПИДЖАК



ОНЛАЙН ХАВАР/ЗУН 2020



YAMA ХАВАР/ЗУН 2020



ГОВЬ ХАВАР/ЗУН 2020



TRENCH COAT
КОЛЛЕКЦИ



ГОЁ ХАВАР/ЗУН 2020



НААДАМ 2020



SUIT КОЛЛЕКЦИ



BLAZER КОЛЛЕКЦИ



ХАТГАМАЛТАЙ ПИДЖАК



ОНЛАЙН ОРГАНИК 2020



FRANCO FERRARO BY GOYO
КОЛЛЕКЦИ



ОРГАНИК НАМАР/ӨВӨЛ
2020



ОНЛАЙН НАМАР/ӨВӨЛ
2020-21 PAINTBOX



ОНЛАЙН НАМАР/ӨВӨЛ
2020-21 MINERAL



ОНЛАЙН НАМАР/ӨВӨЛ
2020-21 WINTER SPICE



ГОЁО НАМАР/ӨВӨЛ 2020



СОАТ КОЛЛЕКЦИ



ГОВЬ НАМАР/ӨВӨЛ 2020



CHRISTMAS КОЛЛЕКЦИ

БИДНИЙ ХАРИЛЦАГЧИД








КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.



Бид 2020 онд компанийн сайн засаглалыг бэхжүүлэн сайжруулах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийсэн.

1. ТУЗ-ийн дэргэдэх хороод чиг үүргийнхээ хүрээнд дараах ажлыг хийсэн. Үүнд:
 - ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж, дүгнэсэн.
 - Компанийн засаглалын өөрийн үнэлгээг хийж Монголын хөрөнгийн бирж болон Компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд тайлагнасан.
 - Эрсдэлийн удирдлагын журмыг шинэчлэн баталсан.
2. Хувьцаа эзэмшигч нарынхаа эрх ашгийг хангах зорилгоор дараах ажлыг хийсэн. Үүнд:
 - Жилийн үйл ажиллагааны тайлангийн агуулгыг шинэчилсэн.
 - Веб хуудсанд "Санал хүсэлт хүлээн авах" буланг ажиллуулж эхэлсэн.

ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Манай компани Монголын хөрөнгийн биржээс батлан гаргасан Хувьцаат компаниудад зориулсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний асуулга” буюу компани өөрийгөө үнэлэх асуулгыг ашиглан Засаглалын өөрийн үнэлгээг 4 дэх жилдээ хийж гүйцэтгэлээ.

№	Үндсэн зарчмууд	Асуултын тоо	Зорилгот үр дүн	Бодит үр дүн						Хэрэгжилтийн хувь		
				Бичиг баримт			Хэрэгжилт			2018 он	2019 он	2020 он
				Авбал зохих оноо	Авсан оноо	Хувь	Авбал зохих оноо	Авсан оноо	Хувь			
A	Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал	20	20.0%	40	34	85.0%	40	35	87.5%	92.5%	83.8%	86.3%
Б	Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал	10	10.0%	20	19	95.0%	20	19	95.0%	95.0%	95.0%	95.0%
В	Оролцогч талууд	10	10.0%	20	17	85.0%	20	18	90.0%	85.0%	80.0%	87.5%
Г	Ил тод нээлттэй байдал	20	20.0%	40	36	90.0%	40	37	92.5%	90.0%	88.8%	91.2%
Д	Төлөөлөн удирдах зөвлөл	30	30.0%	60	52	86.7%	60	53	88.3%	91.6%	85.9%	87.5%
Е	Гүйцэтгэх удирдлага	10	10.0%	20	17	85.0%	20	18	90.0%	90.0%	82.5%	87.5%
Нийт		100	100.0%	200	175	87.7%	200	180	90.0%	90.6%	86.0%	89.1%


Нэгдсэн дүнгээс харахад Говь ХК-ийн 2020 оны засаглалын нэгдсэн үнэлгээ нь 89% -тай сайн засаглалтай буюу компанийн удирдлагын үйл ажиллагаа хэвийн гэсэн түвшинд үнэлэгдэж байна.

ЦААШИД КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХАД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Бид Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, гаднын компаниудын сайн засаглалын туршлагаас суралцан сайн засаглалыг бэхжүүлж, манлайлахаар хичээн ажилласаар ирсэн. Жил бүр хийгддэг засаглалын үнэлгээ нь бидэнд сайжруулах шаардлагатай арга хэмжээг тодорхойлж өгдөг бөгөөд энэ нь бид компанийн засаглалаа улам илүү сайжруулахад түлхэц болж өгсөөр байна. 2020 оны засаглалын үнэлгээний үр дүнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- ХЭ-ийн ээлжит хурлын зар болон материалыг хувьцаа эзэмшигчдэд аль болох цахим хаягаар хүргэдэг болох, цахим харилцааны боломжит хувилбаруудыг улам сайжруулах
- Олон улсын сайн туршлагыг судалж компанийн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулгыг сайжруулах (одоогийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчдын хэрэгцээ шаардлагад нийцэх)
- Дотоод мэдээллийн аюулгүй байдлыг хангах тал дээр тавих хяналтын тогтолцоог илүү сайжруулах
- Компанийн дотоод хяналтыг бодлогыг тодорхойлох
- ХЭХ-ыг долоо хоногийн амралтын өдөр зохион байгуулдаг болох. Ингэснээр хувьцаа эзэмшигчдийг өргөнөөр оролцуулж, эрхээ эдлэх боломжийг илүү олгох.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо /ширхэг/	Эзэмшлийн хувь
ТАВАН БОГД ТРЕЙД ХХК	391,811,700	50.23%
ХИДЕ ИНТЕР ХХК	265,238,300	34.00%

НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ТОО

17,947

/2020.12.31-н ний байдлаар/

ХИДЕ ИНТЕР ХХК

Хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. (Япон улс)

ТАВАН БОГД ТРЕЙД ХХК

нь Таван Богд Группийн толгой компани ба 1997 онд Группийн хэмжээнд бодлого стратегийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан.



Таван Богд Групп нь 18 охин компани, 4 хөрөнгө оруулалттай компани, нийт 11,000 гаруй ажиллагсадтайгаар бизнесийн салбар бүртээ манлайлан ажилладаг Монгол улсын манлайлагч групп компани юм.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага байна. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр 10:00 цагт Outlet дэлгүүр дээрээс зохион байгуулагдав. Дэлхий даяар үүссэн нөхцөл байдал, COVID 19-тэй холбоотой хөл хорионы улмаас Говь ХК хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа анх удаа цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулсан бөгөөд “Gobi Cashmere” албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан шууд дамжуулалтыг хүргэсэн билээ. Хуралд 88.48 хувийн саналын эрхтэй нийт 84 хувьцаа эзэмшигчид оролцож хурлын ирц бүрдсэнээр хурал хүчин төгөлдөр явагдсан бөгөөд нийт 3 асуудлыг хэлэлцэж батлав.

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн “Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2019 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 100%-ийн саналаар батлав.
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг 97.04%-ийн саналаар батлав.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг олонхын саналаар батлав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар зохион байгуулсантай холбоотой бид жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг хангах, хязгаарлахгүй байх талд анхаарч ажилласан бөгөөд олон нийтийн хэрэгслээр мэдээлэл өгөх, урьдчилан санал авах, цахим санал өгөх эрхийн бичгийг өөрийн дэлгүүр дээрээс тарааж санал өгөх эрхийг хангах, хувьцаа эзэмшигч сонирхсон аливаа асуултуудын холбогдох хариулыг хурлын үеэр мэдээллэж ажиллалаа.



КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

/мян.төг/

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2020.12.31	2019.12.31
ТУЗ-ийн цалин урамшуулал	148,400	135,900
Удирдлагын цалин урамшуулал	1,207,538	1,275,133
Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	13,966	13,825

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлдэг. ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг сар тутмын тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлгийг өгч ажиллаж байна. Мөн дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Эрсдэл аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодыг байгуулж, компанийн засаглалыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, Эрсдэл аудитын хорооны удирдлага дор Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдалд хяналт тавих, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавин чиглүүлэх, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

БҮРЭЛДЭХҮҮН

Эрсдэл, аудитын хорооны дарга:
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Б.Нандин-Эрдэнэ

Гишүүд:
ТУЗ-ийн хараат бус гишүүн
А.Жаргалмаа
ТУЗ-ийн ердийн гишүүн
Д.Хулан

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

БҮРЭЛДЭХҮҮН

Нэр дэвшүүлэх хорооны дарга:
ТУЗ-ийн хараат бус гишүүн
М.Баяр

Гишүүд:
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Д.Гэрэлмаа
ТУЗ-ийн ердийн гишүүн
Ц.Баатарсайхан

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

БҮРЭЛДЭХҮҮН

Цалин, урамшууллын хорооны дарга:
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Д.Гэрэлмаа
Гишүүд:
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Такэши Камбэ
ТУЗ-ийн ердийн гишүүн
Ж.Оюунчимэг



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Дамбын
ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн дарга
Хараат бус гишүүн
/Цалин урамшууллын хорооны
дарга, Нэр дэвшүүлэх хорооны
гишүүн/

СЭЗИС, Бизнес удирдлагын
тэнхимийн профессор



Цагаачийн
БААТАРСАЙХАН

ТУЗ-ийн ердийн гишүүн
/Нэр дэвшүүлэх хорооны
гишүүн/

Таван Богд Группийн
Ерөнхийлөгч, Говь ХК-ийн
Гүйцэтгэх захирал



Дашдаваагийн
ХУЛАН

ТУЗ-ийн ердийн гишүүн
/Эрсдэл, аудитын хорооны
гишүүн/

Таван Богд Группийн
Тэргүүн дэд ерөнхийлөгч



Такэши
КАМБЭ

ТУЗ-ийн хараат бус гишүүн
/Цалин урамшууллын хорооны
гишүүн/

Asahi Life Insurance
Менежер



Хидэо
САВАДА

ТУЗ-ийн ердийн гишүүн

N.I.S компанийн Ерөнхийлөгч



Банзрагчийн
НАНДИН-ЭРДЭНЭ

ТУЗ-ийн хараат бус гишүүн
/Эрсдэл, аудитын хорооны
дарга/

СЭЗИС, Бизнес удирдлагын
тэнхимийн ахлах багш



Жавзандолгорын
ОЮУНЧИМЭГ

ТУЗ-ийн ердийн гишүүн
/Цалин урамшууллын хорооны
гишүүн/

Таван Богд Группийн
Маркетингийн газрын захирал



Алтангэрэлийн
ЖАРГАЛМАА

ТУЗ- хараат бус гишүүн
/Эрсдэл, аудитын хорооны
гишүүн/

GAPE, ACCA ахлах багш,
хөтөлбөрийн удирдагч



Мягмарын
БАЯР

ТУЗ-ийн хараат бус гишүүн
/Нэр дэвшүүлэх хорооны
дарга/

ШУТИС-ийн УТС-ийн Хөнгөн
Үйлдвэрлэлийн технологи
инженерчлэлийн салбарын
дэд профессор

ТУЗ-ИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2020 онд нийт 7 ээлжит болон 15 ээлжит бус хурал зохион байгуулж, 27 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилт дээр анхаарч ажиллав. Мөн ТУЗ-ийн дэргэдэх хороод ажлын тайлангаа тогтмол танилцуулж ажилласан бөгөөд хороодын хурал товлосон хугацаандаа амжилттай зохион байгуулагдаж, гишүүд идэвх санаачилгатай ажиллалаа. Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой ТУЗ-ийн хурал, хороодын хурлыг ихэвчлэн зайнаас зохион байгууллаа.

Агуулга	Баталсан тогтоол	Он сар өдөр
Үйл ажиллагаа өргөжүүлэх, хөрөнгө оруулалт	Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	2020.01.10
	Гоёо ХХК-тай холбогдуулан гаргасан шийдвэрийг дэмжин, баталгаажуулах	2020.03.25
Компанийн дотоод үйл ажиллагаа	Компанийн 2020 оны бизнес төлөвлөгөө, зорилтыг батлах	2020.01.22
	Ногдол ашиг хуваарилахгүй тухай	2020.02.14
	2020 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх хэлцэлд зөвшөөрөл олгох	2020.02.14
	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах	2020.03.14
	Тооллогын комисс томилох	2020.03.14
	ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах	2020.05.14
	Байгууллагын нэр дээрх бизнес зээлийн картуудын лимитийн хугацааг сунгуулах	2020.05.27
	Эрсдэлийн удирдлагын бодлого шинэчлэн батлах тухай	2020.06.22
	Гоёо ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг татан буулгах	2020.10.29
Санхүүжилт	Худалдаа Хөгжлийн банкнаас зээл авахыг зөвшөөрөх	2020.02.10
	Зээлийн багц гэрээний хугацаа сунгах, хөрөнгө үргэлжлүүлэн барьцаалах	2020.04.15
	Худалдаа Хөгжлийн банкнаас зээл авахыг зөвшөөрөх	2020.04.17
	ТУЗ-ийн 2019.12.04-ний 30 дугаар тогтоолд нэмэлт заалт оруулах	2020.05.19
	Хөрөнгө үргэлжлүүлэн барьцаалах	2020.05.21
	Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, хугацаа сунгах, хөрөнгө үргэлжлүүлэн барьцаалах	2020.05.25
	Европын Сэргээн Босголт Хөгжлийн банкны зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах	2020.06.04
	Зээлийн нэмэлт гэрээ байгуулах	2020.08.10
	Хөрөнгө сольж барьцаалах	2020.08.13
	Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	2020.09.17
	Хас банкнаас зээл авах зөвшөөрөх	2020.10.05
	Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, хамтран зээлдэгчээр орох	2020.10.19
	Хүний нөөц	Ажилд томилох тухай ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
Гоёо ХХК-ийн Гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас чөлөөлөх		2020.04.21
Гоёо ХХК-ийн Гүйцэтгэх захирлыг томилох		2020.04.21
ТУЗ-ийн даргыг томилох		2020.05.14

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

№	Огноо	Ээлжит хурал	Ирц	Ээлжит бус хурал	Ирц	Нийт баталсан тогтоолын тоо
1	2020.01.10			*	100%	1
2	2020.01.22	*	100%			1
3	2020.02.10			*	100%	1
4	2020.02.14	*	100%			3
5	2020.03.14	*	100%			2
6	2020.03.25			*	100%	1
7	2020.04.13	*	100%			1
8	2020.04.15			*	100%	1
9	2020.04.21			*	100%	2
10	2020.05.14			*	100%	2
11	2020.05.19			*	100%	1
12	2020.05.21			*	100%	1
13	2020.05.25			*	100%	1
14	2020.05.27			*	100%	1
15	2020.06.04			*	100%	1
16	2020.06.22	*	100%			1
17	2020.08.10			*	100%	1
18	2020.08.13	*	100%			1
19	2020.09.17			*	100%	1
20	2020.10.05			*	100%	1
21	2020.10.19			*	100%	1
22	2020.10.29	*	100%			1
Нийт		7		15		27

Тайлбар:

Япон улсад байдаг хоёр гишүүдэд ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлын мэдээллийг цах тухай бүрд хүргэж, саналыг цахим шуудангаар авч, тогтмол харилцаатай ажилладаг.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ТАЙЛАН

ЭРСДЭЛ АУДИТЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдалд хяналт тавих, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавин чиглүүлэх, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

БҮРЭЛДЭХҮҮН

Эрсдэл, аудитын хорооны дарга:
ТУЗ-ийн хараат бус гишүүн **Б.Нандин-Эрдэнэ**

Гишүүд:
ТУЗ-ийн хараат бус гишүүн **А.Жаргалмаа**
ТУЗ-ийн ердийн гишүүн **Д.Хулан**

2020 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Эрсдэл аудитын хороо нь 2020 онд 4 удаа ээлжит хурал зохион байгуулж, 17 асуудлыг хэлэлцсэн. Хорооны чиг үүргийн хүрээнд 11 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг холбогдох албан тушаалтан, албадуудад өгч, хяналт тавьж ажиллав. Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд санхүүгийн тайлан, НББ-ийн талаар хараат бус аудиторын дүгнэлт зөвлөмжтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Эрсдэлийн удирдлагын баг болон дотоод аудитын хэлтсийн ажлын гүйцэтгэл, хагас жилийн болон жилийн ажлын тайлантай цаг тухай бүрд танилцаж удирдамжаар хангасан. Түүнчлэн хөндлөнгийн аудиторын сонгон шалгаруулалтад хорооны гишүүд санал өгч оролцож сонгон шалгаруулав. Мөн эрсдэлийн удирдлагын бодлогыг шинэчлэн баталж дотоод аудитын хэлтсийн 2020 оны үйл ажиллагаа болон цалингийн төсвийг батлав.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

БҮРЭЛДЭХҮҮН

Нэр дэвшүүлэх хорооны дарга:
ТУЗ-ийн хараат бус гишүүн **М.Баяр**

Гишүүд:
ТУЗ-ийн хараат бус гишүүн **Д.Гэрэлмаа**
ТУЗ-ийн ердийн гишүүн **Ц.Баатарсайхан**

Нэр дэвшүүлэх хороо нь 2020 онд 2 удаа ээлжит хурал зохион байгуулж, 6 асуудлыг хэлэлцэв. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 8 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч ажиллалаа. Энэ онд тус хороо нь менежмент багийн жилийн болон хагас жилийн тайлантай танилцаж, тус тайланд гүйцэтгэх захирлаас өгсөн дүгнэлттэй танилцав. Менежмент багийн жилийн тайлан болон гүйцэтгэлд үндэслэн хамт олноо манлайлан удирдаж, амжилттай ажилласан удирдлагуудыг ТУЗ-ийн нэрэмжит шагналд нэр дэвшүүлэн, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шагнав. 2020 оны ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж, үр дүнд нь үндэслэн ТУЗ болон хороодын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд цаашид гүйцэтгэх ажлуудыг хэлэлцсэн бөгөөд Компанийн засаглалын өөрийн үнэлгээг гүйцэтгэж Монголын хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд тайлагнан ажиллалаа.

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

БҮРЭЛДЭХҮҮН

Цалин, урамшууллын хорооны дарга:
ТУЗ-ийн хараат бус гишүүн **Д.Гэрэлмаа**

Гишүүд:
ТУЗ-ийн хараат бус гишүүн **Такэши Камбэ**
ТУЗ-ийн ердийн гишүүн **Ж.Оюунчимэг**

2020 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Цалин урамшууллын хороо нь 2020 онд 2 удаа ээлжит хурал зохион байгуулж, 7 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 3 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч чиглүүлэн ажиллав.

Энэ онд тус хороо нь компанийн хэмжээнд цалин урамшуулал, нийгмийн халамжийн хүрээнд хийгдсэн ажлын тайлан, компанийн соёлын болон сэтгэл ханамжийн судалгааны ажлын үр дүнтэй танилцан санал зөвлөмжийг өгч ажиллалаа.

Мөн хорооны чиг үүргийнхээ дагуу өнгөрсөн оны цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, ирэх жилийн цалин урамшууллын төсвийг баталлаа.

ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

“Говь” ХК-ийн Дотоод аудитын хэлтэс нь компанийн үйл ажиллагаанд Гүйцэтгэх удирдлагын багаас хараат бус, бие даасан хяналт тавьж, улирал бүр ТУЗ-ын дэргэдэх Эрсдэл Аудитын Хороонд тайлагнадаг.

Дотоод аудитын хэлтэс нь “Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ” (IPPF)-г баримтлан, засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үнэлгээ, баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээ, аудитын үйл ажиллагааны чанарын баталгаажуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэн удирдлагыг бодит мэдээллээр ханган, хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг болж ажилладаг.


Аудитын үйл ажиллагааг орчин үеийн чиг хандлага, шилдэг туршлага, мэргэжлийн стандартуудыг цаг алдалгүй судалж, компанийнхаа онцлогт тохирсон баталгаажуулах болон зөвлөх үйл ажиллагааны арга, аргачлал, гарын авлага, горимуудаа байнга шинэчлэх, аудитын сайн туршлагыг бий болгох, үүгээрээ дамжуулан компанийн үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд зорин ажиллаж байна.

2020 онд тодорхойлсон үндсэн чиг үүргийнхээ хүрээнд:

- Баталгаажуулах ажлын хүрээнд нийт 58 анхаарах асуудлыг илрүүлж, тухайн илэрсэн асуудлуудад үүсэх эрсдэл болон шийдвэрлэх санал, зөвлөмжөөр хангаж ажилласан. Аудитын хувьд нийт ажлын 67% нь хөндлөн, 33% нь босоо хэлбэрээр хийж гүйцэтгэсэн. Аудитаар нийт компанийн үндсэн хөрөнгө, үйлдвэрүүдийн үндсэн материал, үйлдвэрүүдийн анхан шатны бүртгэл хөтлөлт, компанийн худалдан авах үйл ажиллагаа, охин компаниуд болон онлайн борлуулалтын үйл ажиллагаа зэргийг тусгайлсан байдлаар авч үзэн хамгаалалтын 1 болон 2 дугаар шугамын үйл ажиллагаа, хяналтын процессыг сайжруулахад шаардлагатай зөвлөмжүүдээр хангаж ажилласан.
- Илэрсэн асуудлуудыг шийдвэрлэх, эрсдэлийг бууруулах, үр дүнг сайжруулах талаар өгөгдсөн зөвлөмжүүд нь 82.1%-ийн хэрэгжилттэй байсан.
- Компанийн засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу үнэлж, компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, тасралтгүй сайжруулах талаар зөвлөмж, дэмжлэгийг өгч ажилласан.

ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Манай компани нь дотоод хяналтдаа “Хамгаалалтын 3 шугам” загварын дагуу зохион байгуулалтыг хийж, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна. Энэ загвар нь шат шатны удирдлагууд өдөр тутмын төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, хянах, зохицуулах үндсэн чиг үүргүүдээ хэрэгжүүлэн ажиллахад ач холбогдолтой байдаг.



ХАМГААЛАЛТЫН I ШУГАМ:

Компанийн үндсэн үйл ажиллагааг явуулж буй нэгжүүд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж, тайлагнадаг.

ХАМГААЛАЛТЫН II ШУГАМ:

Компанийн үндсэн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг нэгжүүд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу өдөр тутмын хяналтыг давхар хэрэгжүүлж, тайлагнадаг.

ХАМГААЛАЛТЫН III ШУГАМ:

Гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтын тогтолцоо нь хэрэгжиж байгаа эсэх, оновчтой байгаа эсэх дээр баталгаажуулалтыг хийж, үндсэн чиг үүргийн хувьд Эрсдэл, аудитын хороонд, захиргааны хувьд Гүйцэтгэх удирдлагад тайлагнадаг.

Ийнхүү чиг үүргийнхээ дагуу давхар тайлагнаснаар Дотоод аудитын хараат бус байдал хангагдаж, бодитой, зохисгүй нөлөөллөөс ангид ажиллаж байна

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

КОМПАНИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАСАГЛАЛ

Засаглалын хувьд “Хамгаалалтын 3 шугам” загварын дагуу эрсдэлийн удирдлагын зохион байгуулалтыг хийн, ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын 2-р шугамын хамгаалалтыг Эрсдэл аудитын хорооноос томилогдсон Эрсдэлийн удирдлагын баг хариуцан ажилладаг. Эрсдэлийн удирдлагын багийг компанийн удирдах албан тушаалтнууд бүрдүүлж байгаа бөгөөд Тэргүүн дэд захирал ахлан ажиллаж байна.



2020 ОНЫ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА


Бид бүхний аюулгүй, эрүүл амьдралын тухай он удаан жилийн тогтсон ойлголтыг 2020 он үндсээр нь өөрчилсөн жил байлаа. Өнгөрсөн жилд урьдчилан таамаглахад бэрх олон даваанууд тулгарч, КОВИД-19 цар тахал бидний эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар ойлголтыг эргэлт буцалтгүйгээр өөрчиллөө. Компанийн зүгээс ч онцгой байдал, давагдашгүй хүчин зүйлд хариу арга хэмжээ авах “Гамшгаас хамгаалах штаб”-ийн гишүүд 2020 оны 02-р сараар эхлэн бүтэн жилийн турш шаардлагатай хариу болон урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч ажилласан билээ.

АЖИЛТАН БА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ
<ul style="list-style-type: none"> Ажлын байрны тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлт, хяналт, шалгалт хийх Хүн хоорондын зай барих болон ажлын байранд нэвтрэх зөвлөмж, үйлчилгээ үзүүлэх Эрүүл мэндийн зөвлөмж, үйлчилгээ үзүүлэх Ажилтанг уян хатан ажлын цаг ба зайнаас ажиллах зохицуулалтаар хангах Хэцүү нөхцөлд байдалда байгаа ажилтанд тусламж үзүүлэх Ажилын байрны тогтвортой байдлыг хангах 	<ul style="list-style-type: none"> Үйлчлүүлэгчид болон нийт оролцогч талууд руу чиглэсэн мэдээллийн урсгалыг сайжруулах Эрүүл мэндийн байгууллага болон онцгой байдлын комисстой нягт хамтран ажиллах Мэдээ мэдээлэл, зөвлөмжийг түргэн шуурхай хүргэх Төсвийн байгууллагууд, Төрийн болон засаг захиргааны байгууллагуудтай ойрхон хамтран ажиллах Эрсдэлтэй бус, орчинд ажиллаж буй албан хаагчдад дэмжлэг, тусламж үзүүлэх 	<ul style="list-style-type: none"> Холбогдох төсөөллийн хүрээнд нөөц төлөвлөгөөнүүдийг боловсруулах, эрсдэл үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох Үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөгөө гүйцэтгэлийг илүү нягт уялдаагаар хангах "Шинэ корона вируст халдварын үед хариу арга хэмжээ зохион байгуулалт" бүхий хөдөлмөрийн аюулгүй байдлын дотоод зохион байгуулалтаар хангах Бэлтгэн нийлүүлэлт, худалдан авалтын үйл ажиллагааны эрсдэлийг урьдчилан хаах 	<ul style="list-style-type: none"> Хямралын үеийн санхүүгийн төлөвлөлт болон гүйцэтгэлийн хяналтаар хангах Мөнгөн урсгалын эрсдэлийг бууруулах арга хэмжээг авах Үндсэн хөрөнгийн эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах Санхүүгийн эрүүл байдлыг хангах хариу арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэх

Өнгөрөгч 2020 он бидэнд эрүүл мэнд, аюулгүй байдал гээд эрсдэлийн удирдлагын хүрээнд маш олон зүйлийг заасан. Үр дүнд нь бид илүү хүчтэй, мэдлэг туршлагаар дүүрэн ирэх оноо угтаж байна. Ингэснээр бид хөдөлмөр хамгаалал, эрсдэлийг бууруулах, түүнээс урьдчилан зайлсхийж, удирдах үйл ажиллагаанд хүн бүрийн оролцоо, хамтын ажиллагааны үнэ цэнийг илүү ойлгож, хэрхэн хамтдаа эерэг өөрчлөлтийг авч ирэх боломжтойг харлаа.


Хамрах хугацаа	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
Үйл ажиллагаа	Эрсдэлийн удирдлага /ЭУ/-ын соёл, хэрэгжилтийг сайжруулах ажлын хүрээнд СЭЗИС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн эрхлэгчтэй үргэлжлүүлэн хамтран ажилласан.	Эрсдэлийн удирдлагын бодлогыг ТУЗ-р батлуулсан	Эд хариуцагчийн хариуцлага, сахилга батыг сайжруулах үүднээс "Хөрөнгө барьцаалах журам"-ыг боловсруулан батлуулсан. Эрсдэлийн удирдлагын процессын болон бүтцийн өөрчлөлт	"Ковид-19 ба эрсдэлийн удирдлага" эрсдэлийн нөлөөлөл болон холбогдох арга хэмжээг тодорхойлон үнэлгээ хийх
Арга хэмжээ	ЭУ-н бодлогыг шинэчлэн боловсруулсан ЭУ-н процесс, журмыг шинэчлэн боловсруулсан ЭУ-н чиг үүргийг хэлтсийн дарга болон түүнээс дээш бүх албан тушаалтнуудад боловсруулан бэлтгэсэн	Ж20-ЭУ-01-03 тоот "Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам"-ыг батлуулсан. Удирдах ажилтнуудад зориулсан эрсдэлийн удирдлагын гарын авлагыг боловсруулж батлуулсан	"Говь" ХК-н хэмжээнд, эд хариуцаж буй ажилчдыг хариуцлагатай байлгах, мөн компанид учрах хор нөлөөг бууруулах зорилгоор эрсдэлийн сан бүрдүүлэх Ж20-ЭУ-02-01 тоот Хөрөнгө барьцаалах журмыг боловсруулан батлуулсан. Нийт 21 албан тушаал дээр 186 ажилтантай эрсдэлийн сангийн гэрээ байгуулж, эрсдэлийн сан бүрдүүлж эхэлсэн	Халдвар хамгаалалыг хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх Онлайн борлуулалт Санхүүгийн сахилга бат Ажилтан ба нийгмийн хариуцлага Ариутгал халдваргүйжуулалт

КОМПАНИЙН БҮТЭЦ



КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ГАРСАН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Дээд шатны удирдлага: Үйл ажиллагаа хариуцсан дэд захирлын орон тоо шинээр бий болгосон.
- Дотоод худалдааны газар: Бүтцийг ашгийн болон ашгийн бус үйл ажиллагаагаар нь салгаж ангилан төлөвлөлт, борлуулалт, маркетингийн хэлтэс болгон шинээр зохион байгуулсан.
- Гадаад худалдааны газар: Ашгийн буюу борлуулалтын хэлтсийг хэвээр үлдээж, ашгийн бус ажилтнуудыг тээвэр ложистикийн алба руу шилжүүлсэн.
- Онлайн худалдааны газар: Европ зах зээлийн 3 газрыг нэгтгэж EU –бүлэг /WEE, Dauch Raum/ болгосон.
- Компанийн мэдээлэл технологийн аюулгүй байдал, нууцлалыг хадгалах, үйлдвэрийн өдөр тутмын үйл ажиллагаа, борлуулалтын мэдээллийн сан бүрдүүлэх шаардлагад нийцүүлэн мэдээлэл технологийн газрын шинээр бий болгов.
- Үйл ажиллагаа өргөжиж, санхүүжилтийн эх үүсвэр татах, шинжилгээ анализ хийх шаардлагад нийцүүлэн Санхүү, стратеги төлөвлөлтийн газрыг шинээр бий болгосон.



ОХИН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Охин компанийн нэр	Байршил	Үйл ажиллагааны чиглэл
1	Говь Кашмер Европ ХХК	Герман улс, Людвигсфельд хот	Худалдаа үйлчилгээ
2	Говь Кашмер (Өвөр Монгол) ХХК	Хятад улс, Эрээн хот	Худалдаа үйлчилгээ
3	Говь Кашмер Америк ХХК	АНУ, Лос Анжелес	Худалдаа үйлчилгээ

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД



ЦАГААЧИЙН
БААТАРСАЙХАН

Гүйцэтгэх захирал



ОТГОНБААТАРЫН
БОЛОРБАТ

Тэргүүн дэд захирал



ЦОГТГЭРЭЛИЙН
ОРГИЛБОЛД

Үйл ажиллагаа хариуцсан
дэд захирал



ГАНБОЛДЫН
СЭЛЭНГЭ

Санхүү хариуцсан захирал



ЧУЛУУНБАТЫН
СОЛОНГО

Хүний нөөц, захиргаа
хариуцсан захирал



БАЗАРРАГЧААГИЙН
ӨНӨБОЛД

Санхүү стратеги
төлөвлөлт хариуцсан
захирал



БАЯРААГИЙН
ЭРДЭНЭ

Мэдээлэл технологи
хариуцсан захирал



БАНДИХҮҮГИЙН
ТҮВШИНЖАРГАЛ

Маркетинг хариуцсан
захирал



ЦОГТБАЯРЫН
ЦАСЧИХЭР

Хуулийн хэлтсийн дарга



БАТПҮРЭВИЙН
НАРАНТУЯА

ТУЗ-ийн нарийн бичгийн
дарга



**БАТСУУРИЙН
БОЛОРМАА**

Дизайн хөгжүүлэлт
хариуцсан захирал



**ЭРДЭНЭЦЭЦЭГИЙН
ЗОЛЗАЯА**

Үйлдвэр удирдлага
хариуцсан захирал



**БАТЧУЛУУНЫ
АРИУНАА**

Дотоод худалдаа
хариуцсан захирал



**ОТГОНТӨГСИЙН
МИШЭЭЛ**

Гадаад худалдаа
хариуцсан захирал



**ЧУЛУУНБАТЫН
ҮНЭНБАТ**

Онлайн худалдаа
хариуцсан захирал
/EU-бүлэг/



**ДАВААНЯМЫН
НАНДИНБАЯР**

Онлайн худалдаа
хариуцсан захирал /DR/



**БАТБАЯРЫН
МӨНХ-ОРГИЛ**

Онлайн худалдаа
хариуцсан захирал /WEE/



**БИЛЭГТИЙН
ТАМИР**

Онлайн худалдаа
хариуцсан захирал /USA/



**ЭНХДАЛАЙГИЙН
МИШЭЭЛ**

Онлайн худалдаа
хариуцсан захирал
/PR OF CHINA/

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ НЭР	ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ	
	ДАНГААРАА	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДҮҮД
Д.ХУЛАН	12,247,300 ширхэг (1.57%)	ТАВАН БОГД ТРЕЙД ХХК 50.23%
Ц.БААТАРСАЙХАН	50,000 ширхэг (0.01%)	
О.БОЛОРБАТ	56,768 ширхэг (0.01%)	
НИЙТ	51.82%	

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА

Говь ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2020.12.31-ний хаалтын ханшаар 150,171,656,250 төгрөг байна. Жилийн арилжааны мэдээллийг графикаар үзүүлэв.



52 ДОЛОО ХОНОГИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ХАНШ

ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12/31	2019 он	2018 он	Өсөлт, бууралт	
				2020/2019	2019/2018
ХУВЬЦААНЫ ҮНЭ /төг/					
Хаалтын үнэ	192.5	270	333.89	28.7% ↓	19.1% ↓
Хамгийн их үнэ	291.86	354.11	369.77	17.58% ↓	4.2% ↓
Хамгийн бага үнэ	164.85	251.98	205.20	34.58% ↓	22.8% ↑
Дундаж үнэ	205.85	291.60	266.80	9.3% ↓	9.3% ↑
АРИЛЖААЛАГДСАН ТОО /шир/					
Хамгийн их /өдөрт/	272,232	261,527	428,390	4.09% ↓	39% ↓
Хамгийн бага /өдөрт/	83	1,068	18	92.23% ↑	5833% ↑
Дундаж /өдөрт/	15,430	31,146	7,862	50.46% ↑	296.2% ↑
Нийт	3,811,314	7,848,937	1,886,927	51.44% ↓	316% ↑
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төг/					
Хамгийн их /өдөрт/	54,440,509	87,630,808	328,449,260	37.88% ↓	73.3% ↓
Хамгийн бага /өдөрт/	16,009	284,711	429,000	94.38% ↓	33.6% ↓
Дундаж /өдөрт/	3,158,074	9,398,943	17,980,871	66.4% ↓	47.7% ↓
Нийт	780,044,366	2,368,533,634	4,315,409,014	67.07% ↓	45.1% ↓
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төг/	150,171,656,250	210,630,375,000	260,471,762,625	28.7% ↓	19.1% ↓

НОГДОЛ АШИГ

Манай компани нь дотоодын зах зээлд байр сууриа хадгалах, улмаар зах зээлд эзлэх хувиа өсгөх, гадаад зах зээлээ тэлэхийн тулд техник, технологио шинэчлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр чармайн ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг тасралтгүй өсгөж, ногдол ашиг тогтмол тараах бодлогыг баримталдаг.

Ногдол ашиг зарласан он	Хувьцааны тоо /шир/	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг /төг/	Нийт зарласан ногдол ашгийн дүн /төг/	Ногдол ашиг тараалт
1996	7,801,125	61.00	475,868,625	Говь ХК нь 2007 онд хувьчлагдсан бөгөөд түүнээс өмнөх жилүүдэд зарласан ногдол ашгийг компани дээрээ тарааж байна.
1997	7,801,125	153.80	1,199,813,025	
1998	7,801,125	150.00	1,170,168,750	
1999	7,801,125	166.00	1,294,986,750	
2000	7,801,125	100.00	780,112,500	
2001	7,801,125	20.16	157,270,680	
2005	7,801,125	60.00	468,067,500	
2006	7,801,125	60.00	468,067,500	
2010	7,801,125	100.00	780,112,500	
2011	7,801,125	100.00	780,112,500	
2012	7,801,125	125.00	975,140,625	
2013	7,801,125	130.00	1,014,146,250	
2014	7,801,125	140.00	1,092,157,500	
2015	7,801,125	140.00	1,092,157,500	
2016	7,801,125	200.00	1,560,225,000	
2017	7,801,125	220.00	1,716,247,500	
2018	780,112,500	6.80	5,304,765,000	2019 оны 4 сарын 25-ны өдрөөс эхлэн компани дээрээ тарааж, хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгох бөгөөд 2019 оны эцэст ногдол ашгийн үлдэгдэл тооцоог гарган Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд нь шилжүүлэх болно.
2019	780,112,500	-	-	2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 04 тоот тогтоолын дагуу 2019 оны ногдол ашиг хуваарилахгүй болно.
2020	780,112,500	-	-	2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 05 тоот тогтоолын дагуу 2020 онд ногдол ашиг хуваарилахгүй болно.



GOBI
MONGOLIAN CASHMERE
100% CASHMERE

GOBI
MONGOLIAN CASHMERE

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ 2020 ОНД

Говь ХК нь ноос ноолуурын салбарын тэргүүлэгч компанийн хувьд салбарын болоод улс орныхоо эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулахыг эрхэмлэн ажилладаг. Бид хүрээлэн буй байгаль орчиндоо сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг ямагт тооцоолж, түүнээс сэргийлэн, нийгмийн хариуцлагаа ухамсарлан, малчид болон орон нутгийн байгууллагуудтай хамтран бэлчээрийн зөв зохистой ашиглалтыг дэмжин ажиллаж, байгальд ээлтэй техник технологийг эрэлхийлэн үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, нөөцийн зүй зохистой хэрэглээг хэвшүүлэхийг зорьдог.

Энэхүү зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны үе шат бүртээ тогтвортой хөгжлийн түлхүүр болсон үзүүлэлтүүдийг орхигдуулалгүй уялдуулан, хэвшүүлж чадсанаар эрүүл эргэх холбоог цогцлоож чадах бөгөөд манай компанийн бизнесийн үйл ажиллагаа урт хугацаандаа улам бүр батжин, улс орныхоо ирээдүй, хойч үед өвлүүлэх баялаг бүтээгч болох болно.

Бид тогтвортой хөгжлийн хүрээнд:

ТОГТВОРТОЙ НООЛУУР ГУРВАН ТАЛТ ХАМТАРСАН ТӨСӨЛ

Төслийн зорилго, цар хүрээ

“Говь” ХК-ийн ХААИС-тай хамтран хэрэгжүүлж буй энэхүү төсөл нь Үйлдвэрлэл-Шинжлэх ухаан-Малчид хоорондын уялдаа холбоог бэхжүүлж малын эрүүл мэнд, арчилгаа маллагаа, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хийж гүйцэтгэх улмаар үржлийн шилмэл хээлтүүлэгчийг үржил селекцийн ажилд ашиглах болон малчдад ямааны ноолуур бэлтгэлийн технологийн зөв дадал эзэмшүүлэх замаар ноолууран түүхий эдийн чанарыг сайжруулж, түүнээс олох малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд оршино.

Үндсэн үйл ажиллагаа

Төслийн хүрээнд дараах үндсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Сонгогдсон сум, багийн малчидтай хамтран ажиллах гэрээ байгуулах
- Малыг эрүүлжүүлэх үйл ажиллагаанд хамтран ажиллах
- Шилмэл омгийн сайжруулагч ухна сонгох
- Ямаан сүргийг ангилах, зохистой бүтцийг тогтоох, хээлтэгч сонгох, бүртгэх
- Сургалт, танилцах аялал
- Үржил селекци /уламжлалт хээлтүүлэг/
- Өвөлжилтийн бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэх
- Төл бүртгэл
- Түүхий эд бэлтгэл, дээж авах, худалдан авалт
- Боловсруулалт, дүн шинжилгээ, тайлан
- Төслийн үр дүнг үнэлэх



STeP EcoLab

Бид 2020 онд Монголын текстилийн салбарын тогтвортой үйлдвэрлэлийн дүрэм-д нэгдэхийн тулд шаталсан сургалтуудад хамрагдсаар байгаа бөгөөд 2021 оны эхний улиралд батламжаа авахаар ажиллаж байна.

ISO СТАНДАРТ

“Говь” ХК нь бизнесийнхээ хөгжлийн чиг хандлагыг ногооруулж, тогтвортой хөгжих үзэл санаанд тулгуурлан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компани болох зорилгоор 2019 оны 04-р сарын 05-ны өдрөөс байгууллагын хэмжээнд Нэгдмэл Удирдлагын Тогтолцооны дараах 3 стандартыг

- Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015,
- Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO14001:2015 стандартыг тус тус нэвтрүүлж эхэлсэн
- Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO45001:2018



Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болон Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандартын төслийн эхлүүлэлт, төлөвлөлт, хэрэгжүүлэлт, мониторингийн үе шатны ажлууд хийгдсэн бөгөөд удирдлагын дүн шинжилгээ болон төслийг хаах (баталгаажуулалт) үе шатанд бэлтгэж байна.

Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны төслийн хувьд ковидын нөхцөл байдлаас шалтгаалж 2021 ондоо багтаан баталгаажуулалтын аудитад орох төлөвлөгөөтэй байна.



“Говь” ХК-ийн дотоодын зах зээлд борлуулагдсан ноолууран пальто болон пиджак бүрээс хуримтлагдсан 1,000 төгрөгийг нийгмийн сайн сайхны төлөөх үйлсэд зориулан ажилласаар байна.

“ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАМГААЛАХ ЭНГИЙН АЛХАМ”



Говь брэнд бүтээгдэхүүн үйлчилгээндээ байгальд ээлтэй даавуун эко торыг сонгон ашиглаж эхлээд байна. Тус даавуун тор (Nonwoven bag)-ны гол орц нь PP (polypropylene) юм. Нэхээсгүй материалын давуу тал нь байгаль орчинд ээлтэй, бат бөх, амьсгалдаг, усны хамгаалалттай, уян хатан, хоргүй байдал юм. Тус тор нь ил задгай нөхцөлд өөрөөр нь байлгахад 90 хоногийн дотор уусаж алга болдог бол өрөөний температурт 8 жил болж уусч алга болдог онцлогтой. Мөн шатаахад ямар ч хорт бодис ялгарахгүй, амтгүй, үлдэгдэл тунадас үлдэхгүй бөгөөд байгаль орчинд нөлөөгүй юм.

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ХАМТ ОЛОН



Говь ХК нь 2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Богд хан уулын Хийморийн овооны аманд 3 га талбайд 1200 ширхэг шинэс болон хуш моддоор ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ АЯН-2020

“Говь” ХК нийт ажилчиддаа Байгаль орчинд ээлтэй зөв хандлага, аюулгүй байдлын соёл зан үйл, дадлыг төлөвшүүлэх зорилгоор БИДНИЙ ОРОЛЦОО “ЭРҮҮЛ- АЮУЛГҮЙ- ЭКО” ОРЧИНГ БҮТЭЭНЭ гэсэн уриан дор нь жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг аяныг 2020.10.22-11.23-ны хооронд амжилттай зохион байгууллаа. Аяны хүрээнд:

Бидний оролцоо “ЭРҮҮЛ – АЮУЛГҮЙ - ЭКО” орчинг бүтээнэ сэдэвт гар зургийн уралдаанд 3-6 нас, 7-12 нас, 13-16 насны 121 хүүхэд зургийн бүтээлээрээ оролцож гэр бүл, эх дэлхийгээ хайрлах тухай өөрсдийн бүтээлдээ дүрслэн ирүүлсэн билээ.



“ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙГ ТОГТОЛЦООГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ” сэдэвт илтгэлийн уралдаанд Газар, Үйлдвэр, Хэлтсийн төлөөлөл бүхий 14 илтгэгч оролцож менежментийн талаар ойлголт, сайн туршлага, хэрэгжүүлж буй ажил, үр дүнгээсээ хуваалцаж шинэ санал, санаачлага, туршлага судлалаа.

“ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЛЭГ” сэдэвт АХА уралдаанд Газар, Үйлдвэр, Хэлтсээс 45 ажилтан оролцож ХАБЭА-н холбогдох хууль, дүрэм, журам, танин мэдэхүйн ойлголтоороо өрсөлдлөө.



Хаягдал лааг дахин ашиглаж эхэллээ. 160 кг хаягдал нь 8,000 ш лаа буюу нэгжийн үнэ нь 958 бол бид 7,669,280 төгрөгийг хэмнэж Японоос лаа захиалах 5 сарын нөөцийг бий болгож эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж байгальд ээлтэй ажлыг хийж чадлаа.

“АЖИЛТАН-ГЭР БҮЛ-АЖИЛ ОЛГОГЧ” БИДНИЙ ОРОЛЦОО ХАМТЫН АЖИЛЛАГАА



БИ ХАБ-н ажилтан ГУРВАЛСАН ХОЛБООГ БЭХЖҮҮЛЭХ зорилготой гэр бүлийн өдөрлөгт хамгийн холоос Өмнөговь аймгийн Гурван тэс сумаас зорьж ирсэн бол хамгийн БЯЦХАН ХАБ-н ажилтан маань 2 настай байлаа.

Өдөрлөгөөр бид ажилтны гэр бүлд ажлын байрны онцлог аюулгүй байдлын зааварчилгаа, хориглох зүйлсийн талаар тайлбарлаж цаашид хамтын ажиллагаагаа бэхжүүлэн ажиллахаар боллоо.

Ажилтны ажлын байрны нөхцөлийг гэр бүлийн гишүүд мэддэггүйгээс сэтгэл зүйн хувьд хүндрэлүүд маш их гардаг байсан бол өдөрлөгийг зохион

байгуулснаар эерэг өөрчлөлтүүд гарсан.

Осолд дөхсөн, осол гарсан үед гэр бүлийн гишүүд ажлын байрны онцлог, хориглох зүйлс зэргийг мэддэггүй учир ойлголцоход хүндрэлтэй байдаг. Эдгээр шалтгаанууд нь дүрэм, журам, зааварчилгааг мөрддөггүйгээс үүсч болохыг гэр бүлийн гишүүд ойлгож гэртээ бүрэн гүйцэд амарч мөн ажлын байран дээрээ аюулгүй ажиллагааг баримтлан ажиллахыг сануулж байна гэж сэтгэгдлүүдээ илгээлээ.

QR КОД УНШУУЛААД Л ГОВЬ ХК-ИЙН БОДЛОГО ЖУРАМТАЙ ТАНИЛЦАЖ, АУДИО ХЭЛБЭРЭЭР СОНСОХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО

- Аюулгүй ажиллагааны талаар байнгын мотиваци авах
- Олон нийтийг далайцтай хамрана /ухаалаг утастай байхад л болно/
- Цаг хэмнэх /чөлөөт цагаараа сонсоод явах боломжтой/
- Компаний талаарх мэдээллийг цаг тухайд авах
- Дотоод журам, хөдөлмөрийн хууль зэрэг хэрэгцээт мэдээлэл авах

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ХАМТ ОЛОН

Говь ХК нь 2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Богд хан уулын Хийморийн овооны аманд 3 га талбайд 1200 ширхэг шинэс болон хуш моддоор ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2020 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Говь ХК-ийг төлөөлж ХЭМАБ-БОХ, Сургалт хөгжлийн алба, ҮТХ, Оёмолын үйлдвэр зэрэг газруудын ажилчид төлөөлөн Хийморийн овооны аманд хийгдэх ажилтай танилцсан.



Бид байгалийн нөөцийг зохистой ашиглан байгалийн нөөцийг нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчноо хамгаалах үүднээс 1200 ширхэг мод тарьж агаарын бохирдол, орчны тоос шороо, шуугиан зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд гар бие оролцлоо.

Цаашид Ногоон хишигтэн ТББ-тай хамтран ажиллах 01/127 тоот дугаар бүхий гэрээний дагуу суулгацыг нөхөн тарих, бордох, арчилгаа, усалгаа зэргийг 3 жил хариуцан ажиллана.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



ИД ШИДТЭЙ ХАМТ ОЛОН

Эх үрсийн баярын өдөр Ид шидийн орон төвийн түр хамгаалах байранд байрлаж буй хүүхдүүд болон Говь ХК-ийн ажилтнуудынхаа нийт 3,100 хүүхдийг баярлуулав.



ХЭЦҮҮ ҮЕД ХАМТДАА

Цар тахалтай холбоотойгоор онцгой нөхцөлд ажиллаж буй цагдаагийн албан хаагчид болон эмнэлэг, мэргэжлийн хяналтын ажилтнуудыг халуун аарц, хоолоор дайлан ард иргэдийнхээ төлөө ажиллаж байгаад нь талархсанаа илэрхийлэв. Мөн компанийн өрх толгойлсон, гэр бүлдээ ганцаараа ажил эрхэлдэг 179 ажилтанд хүнс, түлшний тусламж үзүүлэв.

ГЭР БҮЛИЙН ӨДӨРЛӨГ

Өнөөгийн Говь ХК-ийг бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулж буй ажилтнуудынхаа түшиг тулгуур сайн ар тал нь байж үргэлж дэмжиж тусалдаг гэр бүлийн гишүүдийг нь үйлдвэр болон ажлын орчин нөхцөлтэй нь танилцуулах ГЭР БҮЛИЙН ӨДӨРЛӨГ-ийг зохион байгуулав.



ЧАНАРЫН УДИРДЛАГА

Говь ХК нь түүхий эдээ малчдын гараас хүлээн авахаас эхлэн бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүхий л шат дамжлагад 230 үзүүлэлтээр чанарын шалгалтыг хийж, технологийн горимыг чанд мөрдөн, бүтээгдэхүүнээ олон улсын ISO 9001:2008/MNS ISO 9001:2010, ISO/IEC 17025:2005/ MNS ISO/IEC 17025:2007 стандартын шаардлагын дагуу үйлдвэрлэж, баталгаажуулан дотоод, гадаад, онлайн хэрэглэгчдэд хүргэдэг.

Бид хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр үйлдвэрлэлийн шат дамжлага бүрээр чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн, Монгол Улсын 102 стандарт, компанийн 3 бодлого, 115 журам, технологийн горим, ажлын зааварчилгааг мөрдөж, чанарын хяналт шалгалтыг 100% хийж, чанарын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулан ажиллаж байна.

2020 онд бид Ээрмэл утсанд олон улсын OEKO-TEX стандартын гэрчилгээг авсан. OEKO-TEX нь түүхий эд бүтээгдэхүүн хүний биед хортой бодисын үлдэгдэл байгаа эсэхийг шалгаж баталгаажилт олгодог.



ГОВЬ ХК
БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2020 оны 12-р сарын 31

/Аудитлагдаагүй/

ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2020.12.31

АГУУЛГА

ХУУДАС

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	1
Нэгтгэсэн иж бүрэн орлогын тайлан	2
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	3
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	4

ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
 НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2020 ОН
 (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2020.12.31	2019.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	12,694,714	10,641,744
Дансны ба бусад авлага	6,048,584	12,976,180
Урьдчилгаа төлбөр	2,968,551	4,215,397
Бараа материал	193,207,689	178,135,943
Орлогын албан татварын авлага	265,286	266,632
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	646,063	565,290
	215,830,886	206,801,186
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	156,243,324	134,043,015
Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	2,631,104	2,371,039
Хойшлогдсон татварын хөрөнгө	4,073,481	2,710,343
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	950,981	574,327
	163,898,890	139,698,724
Нийт хөрөнгийн дүн	379,729,776	346,499,910
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны ба бусад өглөг	21,299,848	37,803,959
Орлогын албан татварын өглөг	46,241	
Буцаах эрхтэй барааны өр төлбөр	1,010,634	913,198
Түрээсийн өр төлбөр	1,001,198	686,742
Гэрээний өр төлбөр	1,516,467	2,153,354
Богино хугацаат банкны зээл	267,714,096	189,267,962
	292,588,484	230,825,215
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөр	14,955,172	2,085,657
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	1,900,851	1,865,656
Урт хугацаат банкны зээл	4,458,498	32,560,000
	21,314,521	36,511,313
Нийт өр төлбөрийн дүн	313,903,004	267,336,528
Эзэмшигчдийн өмч		
Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл	48,974,836	15,647,697
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(760,259)	(278,529)
Хуримтлагдсан ашиг	16,832,082	63,014,101
	65,826,772	79,163,382
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	379,729,776	346,499,910

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2020 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	<i>2020.12.31</i>	<i>2019.12.31</i>
Борлуулалтын орлого	117,098,149	209,748,268
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(71,529,282)	(141,951,917)
Нийт ашиг	45,568,867	67,796,351
Санхүүгийн ба бусад орлого	2,537,763	711,312
Бусад олз ба (гарз)	(8,480,689)	(3,445,430)
Хүүгийн зардал	(29,542,260)	(21,811,123)
Борлуулалт ба маркетингийн зардал	(44,346,549)	(27,941,691)
Ерөнхий ба удирдлагын зардал	(13,076,638)	(10,243,248)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	(170,306)	(978,735)
Татварын өмнөх ашиг	(47,509,811)	4,087,436
Орлогын татварын зардал	1,327,791	(1,630,963)
Тайлант жилийн цэвэр ашиг	(46,182,020)	2,456,473
Дараа үеүдэд ашиг, алдагдал руу ангилагдах бусад иж бүрэн орлого:		
Гадаад дахь охин компаниас үүссэн валют хөрвүүлэлтийн зөрүү	(481,730)	(143,326)
Бусад дэлгэрэнгүй алдагдал	(481,730)	(143,326)
Нийт дэлгэрэнгүй орлого	(46,663,750)	2,313,147

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2020 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт
2019 оны 01 сарын 31-ний үлдэгдэл	780,113	15,647,697	(135,203)	101,361,568	117,654,175
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	2,456,473	2,456,473
Бусад дэлгэрэнгүй алдагдал			(143,326)	-	- 143,326
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого			(143,326)	2,456,473	2,313,147
Бизнесийн нэгдлийн нөлөөлөл	-	-	-	(35,499,175)	(35,499,175)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(5,304,765)	(5,304,765)
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	15,647,697	(278,530)	63,014,101	79,163,382
Тайлант жилийн цэвэр ашиг				(46,182,020)	(46,182,020)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		33,327,139	(481,730)		32,845,410
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	-	33,327,139	(481,730)	(46,182,020)	(13,336,610)
Зарласан ногдол ашиг	-	-	-		-
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	48,974,836	(760,259)	16,832,081	65,826,772

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2020 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	<u>2020.12.31</u>	<u>2019.12.31</u>
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(30,669,154)	42,190,870
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(6,250,007)	(34,808,805)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	38,585,512	(1,731,818)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,666,351	5,650,247
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	386,619	50,557
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,641,744	4,940,940
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,694,714	10,641,744

МОНГОЛ ДАХЬ ДЭЛГҮҮРҮҮДИЙН БАЙРШИЛ

ҮЙЛДВЭРИЙН ДЭРГЭДЭХ ТӨВ ДЭЛГҮҮР

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн
чөлөө, Үйлдвэрийн гудамж
Утас: 7004 8888

ДАРХАН ХОТ САЛБАР

Дархан хот, Шинэ Дархан Олон Улсын Худалдааны Төв
Утас: 95056656, 99376775

ГАЛЛЕРИА УЛААНБААТАР САЛБАР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Засгийн газрын
ордны зүүн талд
Утас: 7004 8888

ГАДААД ДАХЬ ДЭЛГҮҮРҮҮДИЙН БАЙРШИЛ

САЛБАР ДЭЛГҮҮРҮҮД

BERLIN, GERMANY

GOBI MONGOLIAN CASHMERE
Knesebeckstr.30, Berlin, Germany
www.gobicashmere.com
+49 (0)30 224 66510

ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРҮҮД

ASIA

ANKARA, TURKEY

GOBI CASHMERE
Armada 1, 1.kat No:136, Eskişehir Yolu No:6 06560
Söğütözü
Tel: +90 (312) 219 16 01-02,
Fax: +90 (312) 219 16 03
Email: info@gobi.com.tr,
Web: www.gobi.com.tr

ISTANBUL, TURKEY

MONGOLIAN CASHMERE GOBI
HARBİYE MAHALLESİ ABDİ İPEKÇİ CADDESİ BRONZ
SOKAK NO: 7D POSTA KODU: 34367 ŞİŞLİ -İSTANBUL,
TÜRKİYE

ALMATY, KAZAKHSTAN

ГОБИ
Проспект Абылай Хана 62, Алма-Ата
+772 731 17035

ERLIAN, INNER MONGOLIA, CHINA

No.010112 Quanjin Road Xilin street, Erlian haote,
Inner Mongolia, China

HAILAAR, CHINA

No.3-2, Dongda street, Hailar dictrict, Hulunbur city,
Inner Mongolia, China

HUHHOT, CHINA

GOBI CASHMERE
Zhongshan West Road, Hohhot

HONG KONG, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE
RM 18-20, 17/F, Horizon Plaza, 2Lee Wing street, Ap
Lei Chau, Hong Kong, China
+852 2730 3911

HONG KONG, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE
Man Yee building, 68 Des Voeux road Central, 2nd floor,
Shop 214, Central, Hong Kong

HONG KONG, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE
Man Yee building, 68 Des Voeux road Central, 2nd floor,
Shop 214, Central, Hong Kong

ULANHOT, INNER MONGOLIA, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE
New century square, 42-11, Wulanhaote city, Inner
Mongolia, China

MANZHOU, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE
China and Russian Duty Free trade zone B Hall, M203,
Manzhouli, China

SEOUL, KOREA

GOBI KOREA
Room 201, Jinsung B/D, Abujungro 4 gil 13-9,
Gangnam-gu, Seoul, Korea
+02 518 0525

SEOUL, KOREA

GOBI KOREA
843, Seolleung-ro, Gangnam-gu, Seoul, Korea
+02 518 0525

SEOUL, KOREA

GOBI KOREA
843, Seolleung-ro, Gangnam-gu, Seoul, Korea
+02 518 0525

TOKYO, JAPAN

Haneda Airport, 1 Terminal, Market place 4F

EUROPE**PRAGUE, CZECH**

GOBI KAŠMÍR
V Jame 3, 110 00 Praha 1, Czech
+42 (0) 702 065 696
www.kasmir.cz

PRAGUE, CZECH

GOBI KAŠMÍR
MAISELOVA 5, 110 00, Praha 1, Czech
+42 (0) 722 066 591
www.kasmir.cz

RUSSIA**ULAN-UDE, RUSSIA**

МАГАЗИНЫ КАШЕМИР ХАУС
Ул Ленина 44, Улан-Удэ, Респ, Бурятия, Россия, 670000
+7 964 414 78 88

IRKUTSK, RUSSIA

МАГАЗИНЫ КАШЕМИР ХАУС
Ул.Советская 3, Деловой Центр, остановка театр
кукоп, Иркутская обл., Россия, 670000
+7 952 629 29 84

NOVOSIBIRSK, RUSSIA

МАГАЗИН "GOBI"
Новосибирск, ул. Вокзальная тагисраль 10/1
Торговый центр "Бонанза"
+7 913 001 66 21

OMSK, RUSSIA

МАГАЗИН "GOBI"
Омск, ТВЦ"Каскад, ул.Карла Маркса 24, 1 этаж,
бутик 11
+7 905 097 01 10

KHABAROVSK, RUSSIA

МАГАЗИН "GOBI"
Хабаровск, ул. Муравьева-Амурского, стр.7, 3 этаж
+8 914 158 77 06

KIEV, UKRAINE

GOBI PREMIUM CASHMERE
Ул.7А Леся Украинка

KYZYL, RUSSIA

GOBI MONGOLIAN CASHMERE
Рес Тыва, г. Кызыл, ул. Чульдума 31, тд Алексеевский

GOBI
MONGOLIAN CASHMERE

"ГОВЬ" ХК, ҮЙЛДВЭРИЙН ГУДАМЖ, 3-Р ХОРОО, ХАН-УУЛ ДҮҮРЭГ,
УЛААНБААТАР-17062, МОНГОЛ УЛС, Ш/Х 36/434
УТАС: +976 7013-9977, ФАКС: +976 7014-3081
И-МЭЙЛ: INFO@GOBI.MN